БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА, ДУНД АНГИЙН ЗАЛГАМЖ ХОЛБООГ САЙЖРУУЛАХ, ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАЖ БУЙ СУРАЛЦАГЧИЙН ДАСАН ЗОХИЦОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР

2023

Агуулга

Удиртгал 3

Ерөнхий боловсролын 5 дугаар ангиас 6 дугаар ангид шилжих үед суралцагчдын ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР-ыг дэмжих нь яагаад чухал вэ? 5

Суралцагчийн дасан зохицох чадварыг хичээл бүрээр дэмжих боломжтой юу? 6

Ээлжит хичээлээр суралцагчийн дасан зохицох чадварыг хэрхэн дэмжих вэ? 8

Суралцагчийн дасан зохицох чадварыг багшлах арга зүйгээр хэрхэн дэмжих вэ? 14

Суралцагчийн дасан зохицох чадварыг үнэлгээгээр хэрхэн хөгжүүлэх вэ? 20

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу? 23

Багш эцэг эх, асран хамгаалагчтай хамтран суралцагчдын дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу? 25

Сургуулийн хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бага ангиас дунд ангид шилжин суралцах үеийн суралцагчдын дасан зохицох чадварыг хэрхэн тусгах вэ? 28

Багш нарын хамтын ажиллагаагаар хүүхдийн дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу? 29

Сургуулийн удирдлага багш нарын мэргэжлийн удирдлагад суралцагчийн дасан зохицолтыг тусгах боломжтой юу? 32

Ашигласан материал 34

Удиртгал

Монгол улсад боловсрол эзэмших тогтолцоо нь тогтвортой, уялдаатай, уян хатан, төр олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай, насан туршийн суралцахуйг дэмжсэн байх зэрэг зарчимтай, боловсролын агуулга нь суралцагчийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн байдлаар хэрэгжихийг Боловсролын Ерөнхий хуульд заажээ.

Хөгжлийн сэтгэл зүйн талаас үзвэл, бага ангиас дунд ангид шилжин суралцах нь физиологи - сэтгэл зүйн эмзэг шилжилтийн үе тул нийгмийн зүгээс ялангуяа эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэгийг шаардаж байдгийг бид бүхэн мэддэг.

Шилжилтийн энэ үед хүүхэд өөрийн зан төлөвөө хянаж зохицуулах, гадаад орчны шаардлагад дасан зохицох зэрэг нь бэрхшээлтэй санагдаж илүү ихээр хүчин чармайлт гаргах болдог. Зарим тохиолдолд ийнхүү дасан зохицож чадаагүйн улмаас хөгжлийн хоцрогдол, доголдолд орж сурлагаар хоцрогдох, сурах хүсэлгүй болох, сургуулиас зайлсхийх, өөртөө итгэлгүй, зан төлөв, харилцааны зөрчилд орох гэх мэт олон сөрөг үр дагавар бий болдог байна.

Ер нь, бага ангиас дунд ангид шилжин суралцах үе нь боловсролын бусад түвшний шилжилтээс хамгийн чухал нь юм. Олон багш нар хичээл орох, хичээлийнтоо нэмэгдэх, агуулга гүнзгийрэх, багш, үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцаанд өөрчлөлт орох (*өөр хүүхдүүдтэй нэг анги болох, шинэ найз нөхөд бий болох зэрэг нь зарим талаар бэрхшээлтэй санагдана)* , дүрэм хэм хэмжээ өөрчлөгдөх гэх мэт асуудлууд бий болдог.

Иймд бага ангиас дунд ангид шилжих үед хүүхдүүдийн нас, сэтгэл зүйн онцлогт нийцсэн дэмжлэгийн стратегийг баримтлах нь үр дүнтэй бөгөөд энэ нь шилжилтийг алгуур зөөлөн хийхэд чиглэнэ.

2019-2020 онд Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг судлах судалгааны үр дүнгээс үзэхэд 5-р ангийн хүүхдүүдтэй харьцуулахад, 6-р ангид хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, хариуцлагатай зан төлөв, сэтгэл санааны тогтвортой байдал буурч, зан төлөвөө зохицуулах, бусдыг хүлээн зөвшөөрөх, бусдад анхааралтай хандах, идэвхтэй зан төлөв, сэтгэл санааны тогтвортой байдал, эцэг эхтэйгээ харилцах, тэдэнд итгэх итгэл, олон нийтийн газар биеэ авч явах чадвар буурч, сэтгэл санааны түгшүүр тодорхой хэмжээгээр нэмэгджээ. Мөн бие бялдрын хөгжлийн хувьд хүүхдүүдийн хурдны чанар статистик ач холбогдлын түвшинд буурсан ба энэ нь идэвх, сонирхол буурсантай холбоотой байж болно.

Судалгааны үр дүнгээс

5-р ангийн хүүхдүүдтэй харьцуулахад, 6-р ангид:

- Өөртөө итгэх итгэл 4 хувиар, хариуцлагатай зан төлөв 12 хувиар, сэтгэл санааны тогтвортой байдал нь 25 хувиар буурч, айдастай зан төлөв 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Эцэг эхтэйгээ харилцах харилцаа 28 хувиар, идэвхтэй зан төлөв 7 хувиар, бусдад анхаарал тавьж харилцах нь 18 хувиар, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь 21 хувиар, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдан зохицуулах чадвар 10 хувиар, олон нийтийн газар бие авч явах чадвар нь 3 хувиар тус бүр буурсан үзүүлэлттэй байна (БСҮХ, 2023).

Танин мэдэхүйн хөгжлийн хувьд, нас сэтгэл зүйн зүйн онцлогоо дагаад өссөн үзүүлэлт байгаа хэдий ч оюуны үйлд анхаарлаа төвлөрүүлэх чадвар 10 гаруй хувиар буурч, мэдээллийг утгаар нь тогтоох чадвар сайжраагүй дүр зураг харагдлаа (БСҮХ, 2023).

Аливаад дасан зохицоход наад зах нь 6 сарын хугацаа шаардлагатай бөгөөд улс орны туршлагаас харахад хүүхэд бага боловсролоос суурь боловсролын түвшинд шилжин суралцахаас өмнө, дараа 12-24 сарын хугацаанд дасан зохицолтын дэмжлэгийн стратеги баримталдаг байна. Мөн зан төлөвийн хувьд дасан зохицоход бэрхшээлтэй, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай, эрүүл мэндийн хувьд асуудалтай хүүхдүүдэд нэмэлт дэмжлэг, ганцаарчилсан үйл ажиллагаа чухал гэж үздэг.

Иймд бид ЕБС-ийн бага ангиас дунд ангид шилжин суралцах үеийн дасан зохицоход дэмжлэг үзүүлэн энэхүү зөвлөмжийг багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх асран хамгаалагчдад зориулан боловсруулллаа.

Зөвлөмжийн зорилго

Бага боловсролоос суурь боловсролын түвшинд шилжин суралцах үеийн суралцагчдын дасан зохицох чадвартай холбоотой тулгарч байгаа асуудлыг даван туулахад арга зүйн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Зөвлөмж хэнд зориулагдсан болох

Зөвлөмжийг 5-6-р ангид хичээл заадаг багш нар болон анги удирдсан багш нар хичээл, сургалт хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, үнэлж сайжруулах, хүүхэдтэй харилцах, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллахдаа хэрэглэнэ.

Мэргэжлийн хөгжлийн бүлэг нь багшийн мэргэжлийн удирдлагыг бий болгох, багшийн хамтын үйл ажиллагааг сайжруулахад хэрэглэх бүрэн боломжтой.

Зөвлөмжийг хэрхэн ашиглах

- ✓ Сургууль, ангийн түвшинд хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөхөд баримжаа болгох
- ✓ Сургууль ангийн түвшинд хичээлээс гадуурх сургалт, хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чиглэл болгох
- ✓ Суралцагчдын эцэг, эхтэй хамтран ажиллахад арга зүйн чиглэл болгох
- ✓ Сургууль, ангийн түвшинд суралцагчдын дасан зохицох чадвартай холбоотой үүсэж буй бэрхшээлийг даван туулахад багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн хамтын ажиллагааны чиг баримжаа болгох.

Зөвлөмжийн бүтэц

Зөвлөмж нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

- Дасан зохицох чадварыг дэмжих талаарх ерөнхий ойлголт
- Дасан зохицох чадварыг дэмжих олон талт үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга зам,

- Үйл ажиллагаа бүрд холбогдох жишээ тайлбар

Ерөнхий боловсролын 5 дугаар ангиас 6 дугаар ангид шилжих үед суралцагчдын ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР-ыг дэмжих нь яагаад чухал вэ?

Бага боловсролоос суурь боловсролын түвшинд шилжин суралцах нь өсвөр насны шилжилтийн үетэй цаг хугацааны хувьд давхцах ба олон шинэ өөрчлөлтүүд хүүхдэд бий болдог тул дасан зохицох чадвар шаардлагатай болдог. Өсвөр насны шилжилтийн үе нь биологи-физиологи-сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийг бий болгодог ба хөгжлийн чухал үе юм.

Дасан зохицох чадвар нь хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэж зохицох чадвар. Дасан зохицсоны гол илрэл нь тавигдаж байгаа шаардлага, шинээр буй болсон нөхцөл нь хувь хүнд бэрхшээлгүй болох юм (Н. Бэгз, С.Санжаабадам нар , 2021).

Өсвөр үеийг сургуулийн насны **хоёр дахь дасан зохицох** үе ч гэж нэрлэх нь бий. Эхний дасан зохицох үе нь нэгдүгээр ангид элсэн суралцах үе байдаг. (Н.И.Шевандрин, 1995)

Багш хоёр дахь дасан зохицох үеийн суралцагчийн зан үйлийн талаар ойлголттой байх нь чухал байдаг.

Хүүхдийн харилцаанд өдөр тутам ажиглагддаг зан үйлийн зарим илрэл:

- Сурах үйл нь бэрхшээлтэй санагдах
- Уурлан бухимдах
- Айж түгших
- Бусадтай найзалж нөхөрлөхдөө бэрхшээх
- Зожиг ганцаардмал болох
- Хүүхэд өөрийгөө том болсон мэтээр мэдрэх зэрэг юм.

Эдгээр нь хүүхдэд суралцахуйн бэрхшээлийг үүсгэх магадлал өндөр байдаг. Суралцахуйн бэрхшээлийг даван туулах чадваргүй байдлаас үүдэн дараах сөрөг үр дагаварууд гарах нь элбэг байдаг. Үүнд:

- Багш анги хамт олонтойгоо харилцах сонирхолгүй болох
- Өөртөө итгэлгүй болох эсхүл онгирон сагсуурах
- Хичээлдээ идэвх зүтгэл гаргахгүй байх
- Ирээдүйн нөхцөл байдалд сохроор итгэх
- Өөрийгөө танин мэдэж чадахгүй байх
- Бусдыг аялдан дагах
- Олон нийтийн үйл ажиллагаанаас зайлсхийх
- Буруу дадал зуршлаар бусдаас онцгой мэт харагдахыг хичээх жишээлбэл, бусдад түрэмгий, дээрэлхүү зан авир гаргах, тамхи татх, мансууруулах бодис хэрэглэх, хэм хэмжээ зөрчих, хичээл үйл ажиллагааг таслах гэх мэт зан үйлийг гаргах эрсдэлтэй байдаг.

Суралцагч бага боловсролоос суурь боловсролын түвшинд амжилттай шилжин суралцаж байгаа нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Сэтгэлийн түгшүүргүй, амгалан тайван

- Өөрийн зан төлөвийг хянан зохицуулдаг
- Өөртөө итгэлтэй
- Сурах дур сонирхолтой
- Бусдыг хүлээн зөвшөөрдөг, бусадтай эерэг харилцаатай
- Сургуулийн сайн дурын үйл ажиллагаа, клуб, секцэд хамрагддаг зэрэг зан үйлээр илэрдэг билээ.

Дээрх эерэг хандлагууд нь цаашид дэвшин суралцах, нийгэм-сэтгэл зүйн эерэг хандлагыг бий болгох үр дүнтэй.

Ийм учраас багш сурган хүмүүжүүлэгчид үйл ажиллагааны бүхий л хүрээнд хүүхдийн ДАСАН ЗОХИЦОХ чадварыг дэмжин ажиллах нь мэргэжлийн үүрэг хариуцлага болоод байна.

Суралцагчийн дасан зохицох чадварыг хичээл бүрээр дэмжих боломжтой юу?

ХИЧЭЭЛЭЭР СУРАЛЦАГЧИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ нь 5-6 дугаар ангид хичээл заадаг багш нарын ажлын амжилтын нэгээхэн хэсэг юм.

Ерөнхий боловсролын 5-6 дугаар ангид хичээл заадаг болон анги удирдсан багш нар хамтын ажиллагаагаар хүүхдийн дасан зохицох үйл явцыг дэмжих нь гол арга зам.

Дасан зохицох үйл явцыг дэмжихэд анхаарах ерөнхий чиглэл.

***Бага ангийн** багш суралцагчийг 6 дугаар ангид элсэн суралцах бэлтгэлийг хангахдаа:*

- хичээлийн үед бие даан сурах үйл явцдаа хандах хандлагыг бий болгох
- хичээлийг оролцоонд тулгуурласан, бүтээлч, идэвхтэй аргаар зохион байгуулах
- аливаа асуудал тулгарахад бусдаас дэмжлэг авах чадварт суралцуулах
- бусадтай багаар ажиллах, харилцах чадварыг дэмжихэд хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг чиглүүлэх

Дунд ангийн багш:

- ээлжит хичээл бүрээр суралцагч өөрийн чадварыг багшид болон анги хамт олонд таниулах нөхцөлийг бүрдүүлэх,
- бие даан ажиллах чадварыг дэмжсэн даалгавруудыг суралцагчийн онцлогт тохируулан өгөх,
- аливаа үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх дадлыг дэмжих,

- хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны явцад суралцагчийг ажиглан, дасан зохицох чадвар султай холбоотой бэрхшээл тулгарахаас урьдчилан сэргийлэх,
- хичээл, сургалтаар эзэмших мэдлэг, чадвар, суралцах арга барил, үнэлгээ, багшийн байр суурь зэргийг хичээлийн жилийн эхэнд суралцагчдад сайтар ойлгуулах.
- дунд ангид хичээл ордог болон анги удирдсан багш нар хичээлийн эхэнд суралцагчийн дасан зохицох чадварын түвшин, онцлогийг ажиглан таньж, дэмжлэг үзүүлэх.

Дасан зохицох чадварыг илрэлээр нь дараах байдлаар авч үзэх нь багш энэ чадварыг дэмжихэд ач холбогдолтой. Үүнд:

- *Дасан зохицох чадвар сайтай* - Ийм хүүхэд өөртөө итгэлтэй, өөрийн зан төлөвийг хянан зохицуулдаг, суралцахуйн хувьд бэрхшээлгүй, сурах сонирхолтой, баяр баясгалантай, зорилготой ханддаг, бие даах чадвар сайн.

- *Дасан зохицох чадвартай* - Ийм хүүхэд бэрхшээл, бухимдал, стресст байнга ороод байдаггүй, хичээлдээ зорилготойгоор ханддаг, зарим үед нөхцөл байдлаас шалтгаалан сурах идэвх сонирхол нь буурах, өөртөө итгэлгүй байх, бусдаас хамааралтай тал ажиглагдана.
- *Дасан зохицох чадварыг дэмжих шаардлагатай* - Ийм хүүхэд сурах явцдаа бэрхшээж, бухимдуу, айдастай эсвэл түрэмгий зан авир гаргадаг. Мөн хичээлдээ, багшдаа, цаашилбал сургуульдаа дургүйцэх хандлагатай байх ба ийм төлөв байдал нь багшид илэрхий ажиглагддаг.


Дасан зохицох чадварыг дэмжээгүйгээс дараах сөрөг үр дагаварууд гарч болно.

Үүнд:

- Танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын зарим чадвар сул байх
- Суралцахуйн болон агуулгын хувьд хоцрогдох
- Аливаа бэрхшээлийг даван туулахаас зайлсхийх хандлагатай болох
- Зан үйлийн асуудалтай болох гэх мэт

5-6 дугаар ангид хичээл ордог, анги удирдсан багш нар эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнх нь онцлог, хэрэгцээ, үүсээд байгаа бэрхшээл, цаашид хэрхэн дэмжих талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх нь үр дүнтэй. Энэ нь хичээл, сурлагадаа хандах хандлага, дасан зохицох чадвартай холбоотой үүсэж болзошгүй бэрхшээл, учир шалтгаан, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга зам, суралцагчийн сэтгэлийн хөдөлгөөн, харилцааны дэмжлэгийн талаар байх нь зохимжтой.

Зураг 1. Суралцагчийн дасан зохицох чадварыг дэмжих арга зам




Ээлжит хичээлээр суралцагчийн дасан зохицох чадварыг хэрхэн дэмжих вэ?

Хичээлийн төлөвлөлтөд хэрхэн тусгах вэ?

Хичээлийн төлөвлөлтийн үндсэн хэсэг нь ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ, СЭДЭЛЖҮҮЛЭХ, ЗОРИЛГОО ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ДҮГНЭХ бүрэлдэхүүнтэй ба эдгээр үе шатад багш та хүүхдийн дасан зохицох чадварыг удирдах талаар тусгана.

Зураг 2. Хичээлийн төлөвлөлтөд дасан зохицох чадварыг тусгах





ЗӨВЛӨМЖ

Танин мэдэхүйн чадварыг дэмжих үйлийг тусгахдаа багш та дараах зөвлөмжийг хэрэгжүүлээрэй.

Хүүхэд сургалтын үйл явцад дасан зохицох чадвар сул байгаагаас үүдэн сурахдаа бэрхшээх, анхаарал нь сарних, агуулгыг ойлгохгүй байх, хялбар ядрах цаашилбал, хичээлдээ сонирхолгүй болж сурлагын хоцрогдолд орох магадлалтай. Иймд багш та хүүхдийн танин мэдэхүйн чадварыг хичээлийн явцад дэмжин ажиллаарай.



- Хичээлийн явцад суралцагчдын анхаарлын төвлөрлийг нэмэгдүүлэхийн тулд хичээлийн туршид баримтлах дэгийг боловсруулан мөрдөөрэй.
- Хичээлийн үед суралцагчдын анхаарлыг төвлөрүүлэх үйлийг ойр ойрхон хийгээрэй. Тухайлбал, алга таших, анхааараарай гэж хэлэх, команд өгөх гэх мэт.
- Хэт их даалгаврыг нэг дор удаан хугацаагаар гүйцэтгүүлэх нь тэднийг залхаах, ядраах нөлөөтэй тул зайлсхийж, харин тохирсон даалгаврыг өгч бүрэн гүйцэтгэхэд нь анхааараарай. Энэ нь хүүхдийн анхаарлын төвлөрөл, бүтээлч байдлыг дэмжих нөлөөтэй. Гэрийн даалгаварт мөн үүнийг харгалзаарай.
- Хурд шаардсан, өрсөлдөөнтэй гүйцэтгэх даалгаврыг хийлгэж хүүхдүүдийн анхаарлын тогтворжилт, сэтгэхүйн хурдыг нь дэмжээрэй. суралцагч бүрийн оролцоог хангаарай.
- Мэдээллийг богино хугацаанд харж тогтоох чадварыг нь дэмжээрэй. Үүний тулд нэг удаадаа 5-6 хүртэлх мэдээллийг өгөөрэй. Мэдээллийг харах, сонсох үйлийг зэрэг биш, харин ээлжлэх нь үр дүнтэй.
- Мэдээллийг утгачлан тогтоох чадварыг хөгжүүлэхийн тулд агуулгыг сайтар ойлгуулах үүний тулд давтан тайлбарлах, дүрслэн үзүүлэх, ойлгосныг нь зургаар илэрхийлүүлэх нь арга зүйг хэрэглээрэй. Утачлан тогтоох мэдээллийн багтаамжийг аажим нэмэгдүүлэх стратеги баримтлан дасан зохицох чадварыг нь дэмжээрэй.
- Хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэхийн тулд агуулгыг тэмдгийн системд оруулан тэмдэглэх, нэр томъёог сайтар тайлбарлахыг хичээгээрэй. Ойлгосон зүйлийг нь өөрсдөөрөө бүдүүвч-загварт оруулах үйлдлийг гүйцэтгэх, математик чадварыг хөгжүүлэхэд анхааараарай.
- Юмсыг хооронд нь тоо болон чанарын хувьд харьцуулах, ангилах үйлдлийг хичээлийн элементэд түлхүү оруулах, тухайлбал, зориулалт, дотоод нийтлэг онцлогоор ойлголтыг харьцуулах, ангилах гэх мэт үйлдлийг судлагдахууны онцлогт тохируулан ээлжит хичээлдээ сонирхолтой байдлаар тусгаарай.
- Хэл яриа сэтгэхүйн чадвар болон үгийн санг нэмэгдүүлэхийн тулд судлагдахууны гол ойлголт, нэр томьёог тайлбарлах, ялгаатай болон төсөөтэй шинжээр ангилах дасгал үйлийг төлөвлөлтдөө тусгаарай.
- Юмсын гол утга санааг товч ярих, бүтэн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх даалгаврыг тусгаарай.

- Дүгнэх, учир шалтгааныг илрүүлэхэд чиглэсэн асуултыг оруулаарай.
- Өгөгдсөн нөхцлийн гол шинж, гадаад болон дотоод уялдаа холбоонд нь дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлээрэй.
- Танилцуулга, эсээ бичих аргыг алхам алхамаар тусгаарай.

Судалгааны үр дүнгээс: 5 дугаар ангийн суралцагчтай харьцуулахад, 6 дугаар ангид оюуны үйлд анхаарал төвлөрүүлэх болон нэг үйлээс өөр үйлд анхаарлаа зориудаар шилжүүлэн төвлөрүүлэх чадвар буурсан, мэдээллийг утгачлан тогтоох чадвар нэмэгдээгүй БСҮХ,2021).

Нийгэмшлийн чадварыг дэмжихдээ дараах зөвлөмжийг хэрэгжүүлээрэй.



- Суралцагч бүрийг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд тэгш оролцуулан идэвхтэй зан чанарыг дэмжээрэй.
- Багаар ажиллах, харилцан ярилцах, санаа бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх, урлаг, спортын үйл ажиллагааны тэгш оролцоог хангах замаар бусадтай нийцтэй байх чадварыг нь дэмжээрэй.
- Суралцагчдын бусдын шахалт шаардлагаар аливаа үйлийг гүйцэтгэж буй байдлыг ажиглаж, санал, санаачилгыг нь урамшуулан дэмжээрэй.
- Суралцагчдын өөртөө хандах хандлага, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэхийн тулд хүүхдийн чадварт тохирсон даалгавар гүйцэтгүүлэхийг хичээгээрэй.
- Суралцагчдын хариуцлагатай, идэвхтэй, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, бие даах чадварыг нь хөгжүүлэхэд гэрийн даалгаврын гүйцэтгэлийг үнэлж, харилцан хэлэлцэх аргыг хэрэглээрэй.
- Суралцагчид өөрийн болон найз нөхдийнхөө сэтгэлийн хөдөлгөөнийг таньж, ойлгож харилцах чадварыг зөвлөн туслах, харилцан асууж ярилцах, уран зохиолын дүрийг ярилцах гэх мэт аргуудаар дэмжээрэй.
- Сэтгэл санаагаа нээлттэй илэрхийлэх чадварыг суралцагчдад хүндэтгэлтэй хандах, харилцан яриалцах, ХГҮА-ны оролцоогоор дэмжээрэй.
- Суралцагчийг бусадтай бүү харьцуулаарай. Энэ нь хүүхдэд түгшүүр үүсгэдэг.
- Шинэ хичээлүүдийг шинэ багш нар зааж байгаатай холбоотой сурагчдад түгшүүр үүсэж болохыг тооцоорой. Багш бүр сурагчидтай харилцахдаа элэгсэг нээлттэй, тэвчээртэй, сэтгэлийн хөдөлгөөний сөрөг илрэлээс зайлсхийгээрэй.
- Суралцагчдын бусдаар өөрийгөө хүндлүүлэхийн чухлыг мэдрүүлсэн харилцааг үүсгээрэй. Би бусдыг хүндэтгэж харилцахаас гадна бусад хүмүүс намайг бас хүндэтгэж харилцана гэдгийг ойлгуулаарай.

Судалгааны үр дүнгээс: 5-р ангийн хүүхдүүдтэй харьцуулахад 6 дугаар ангид хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, зан төлөвөө зохицуулах, бусдыг хүлээн зөвшөөрөх, анхааралтай хандлага, идэвхтэй зан төлөв, сэтгэл санааны тогтвортой байдал, эцэг эхтэйгээ харилцах, тэдэнд итгэх итгэл, олон нийтийн газар биеэ авч явах чадвар буурч, сэтгэл санааны түгшүүр бага зэрэг нэмэгдсэн байна (БСҮХ,2021).

Бие бялдрын чадварыг дэмжихдээ дараах зөвлөмжийг хэрэгжүүлээрэй.



- Суралцагчдыг хичээлийн туршид идэвхтэй, чөлөөтэй хөдөлгөөнтэй байх сургалтын зохион байгуулалтын хэлбэрийг аль болох сонгоорой.
- Суралцагч удаан хугацаагаар нурууны булчинг чангалан суух нь анхаарлаа төвлөрүүлэх чадварт сөргөөр нөлөөлдөг тул зөв суух дадлыг хэвшүүлэх, дасгал хөдөлгөөн хийлгэж хэвшээрэй.
- Гарын жижиг булчинг дэмжсэн даалгаврыг ачааллыг нь хэтрүүлэхгүйгээр гүйцэтгүүлээрэй.
- Хөдөлгөөний уян хатан эвслийг хөгжүүлэхэд үр дүнтэй арга зүйн элементийг хичээлдээ бүтээлчээр тусгахыг хичээгээрэй.

Судалгааны үр дүнгээс: 5-р ангийн хүүхдүүдтэй харьцуулахад, 6 дугаар ангид хүүхдүүдийн хурдны чанар буурсан (БСҮХ,2021).

Жишээ

Хичээлийн нэр: Монгол хэл

Сэдэв: *Үгсийн сан*

Суралцахуйн үе шат	Суралцахуйн үйл	Арга зүй	Хугацаа
Зорилго танилцуулах	Байнга давтагддаг үйл явдлыг англи хэл дээр хэлж сурах дадал эзэмших	Багш хичээлийн үед анхаарлыг нь төвлөрүүлэн мэндэлж, хичээлийн сэдэв, зорилгыг танилцуулна. Багш хичээлийн үе шатыг танилцуулна.	
Хичээлийн дүрэм батлах:	Хичээл дээр баримтлах дүрмийг хүүхдүүд хэлж, батална. (бусдыг ойлгож сонсох, анхааралтай багшийн болон бусдын хэлж байгаа мэдээлэл, зааврыг сонсох, бусдынхаа яриаг таслахгүй хүндэтгэж харилцах, багаараа ажиллахдаа бүгд саналаа тусгах, хэлэлцэх, өөрийнхөөрөө ярих гэх мэт)	Багш хичээлийн үед баримтлах дүрмийг хүүхдүүдээр хэлүүлж өнгийн шохой ашиглан самбарт бичнэ.	
Зохион байгуулалтыг танилцуулах	Багш хичээлийн туршид ямар үйл хэрхэн хийгдэх талаар танилцуулна.	Багш хичээлийн туршид хийдэх үйлүүдийг дэлгэц цаас эсвэл самбарт бичиж хүүхдүүд харагдахаар	

		тодоор харагдахуйц газар байрлуулна.	
Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, туршлага	Шинэ үгс сурах, өгүүлбэрээр үйл явдлыг илэрхийлэх Шинэ дуу сонсох/үзэх Хүүхдүүдэд шинэ дууг сонсгох/бичлэг үзүүлнэ. Аянд нь бүжиглэх Дагаж дуулах Мэдэхгүй үгсээ бичиж авах, орчуулах Хүүхдүүд баг болж сурсан шинэ үгээ үйлдлээр үзүүлж таах тоглоом тоглох Дууны утга санааг 1-2 өгүүлбэрээр дүгнэж илэрхийлнэ.	Багш өмнөх хичээлийн агуулгыг товчхон тайлбарлан сануулна. Хүүхдүүдийг тоо тоолуулан тэгш сондгой тоогоор нь 3-5 хүнтэй баг болгоно. Тоглоомын арга Хэлэлцүүлгийн арга хэрэглэнэ.	
Дүгнэлт	Оролцоог урамшуулах үйл хийгдэнэ. Хичээлээ хүүхдүүд дүгнэнэ.	Хүүхдүүдийн амжилтыг бодитоор аман байдлаар болон оноо өгөх аргаар үнэлнэ. Багийн онооны нийлбэрээр оролцоог нь үнэлнэ. Хүүхдүүд хичээлээр юу мэдэж, чаддаг болсныг англиар 1-2 өгүүлбэрээр багаараа хэлэлцэж дүгнэнэ. Багш талархал илэрхийлнэ.	
Гэрийн даалгавар өгөх	Дуугаа сурах, шинээр сурсан үгээрээ 3-5 өгүүлбэр зохиох	Даалгаврыг хэзээ хийх, ямар үнэлгээ авахыг тодорхой хэлж өгнө .	

Сэдэлжүүлэлт

Сэдэлжилт нь суралцахуйн үйлийн хамгийн анхдагч шат юм. Сэдэлжилт нь хүүхэд сурах үйлд сонирхол нь татагдах, сурах зүйлдээ зорилго эрмэлзэлтэй хандах, сурах зан үйлээ бие даан удирдах, сурах тогтсон дадалтай болохыг хэлнэ.

Багшийн ээлжит хичээлийн үйл нь хүүхдэд дээрх зан үйлийг чиглүүлэхийг сэдэлжүүлэлт гэж нэрлэж болно.

Сэдэлжүүлэх үйл ажиллагаа нь дараах бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- Хүрэх үр дүн буюу зорилгыг ойлгуулах
- Агуулгыг сонирхох, тухайн сурах үйлийг гүйцэтгэх хүсэл эрмэлзэлийг төрүүлэх
- Сурах дадлыг бий болгох үйлийг хийх/сурах өөрийн гэсэн арга барилыг бий болгох
- Амжилттай сэдэлжилтийн гол шалгуур нь *“сурах үйл “тулган шаардалт биш байх” юм”.*

Сурах хүсэл эрмэлзлэлтэй суралцагчийн шинжүүд:

- ✓ Өөдрөг, баяр баясгалантай – Сурах үйл, хичээлдээ сэтгэл зүйн хувьд өөдрөг сонирхолтой хандана.
- ✓ Хичээл зүтгэлтэй- сурах үйлдээ тууштай, тулгараад байгаа асуудлыг даван туулах чадвартай

- ✓ Идэвхтэй – Хичээл сургалтын туршид асуудал, зорилтыг шийдвэрлэхэд оролцоотой байж чаддаг.
- ✓ Анхаарлаа төвлөрүүлдэг- Хичээл сургалтын бүхий үйлд анхаарлаа төвлөрүүлэн бүтээлчээр ажилладаг.
- ✓ Өөртөө итгэлтэй- Өөрийн давуу талаа сайн мэддэг, юуг чаддагаа, юугаараа бусдаас илүү гэдгээ мэддэг, үүнээс гадна сул талаа ч мэддэг, үүндээ сэтгэлээр унадаггүй, эмзэглэдэггүй, бусдын сайн талыг хүлээн зөвшөөрч чаддаг.

Дээрх зан төлөв хүүхдэд ажиглагдвал багш таны сургалт хичээл үр дүнтэй байна гэсэн үг юм. Багш та бидний сургалт хичээлийн үйлүүд эдгээр чанарыг төлөвшүүлэхэд чиглэвэл үр дүнтэй байж чадна.



зөвлөмж

- ➢ Хийж гүйцэтгэх үйлдэл, үүргийг нь хичээлийн эхэнд тодорхой ойлгуулаарай.
- ➢ Багш хичээлийг сонирхолтой заагаарай.
- ➢ Багаар ажиллаж буй тохиолдолд гишүүн бүрийн оролцоог хангаарай.
- ➢ Хүүхэд дасгал, даалгаврыг гүйцэтгэхдээ зорилгодоо хүрсэн бол урамшуулан дэмжээрэй.
- ➢ Хүүхдийн асуулт бүрт хариулаарай.
- ➢ Ямар ч үед хүүхдийн алдааг хүүхдээр засуулах нь **тэгш бус хандлага** гэдгийг анхааараарай. .
- ➢ Бусад хүүхэд, хамт олны нь дунд нэр хүндийг нь эрхэмлээрэй.
- ➢ Хүүхэд ярьж байгаа үед ижил тэгш харилцаж буйгаа ойлгуулан нүүр лүү нь хараарай.
- ➢ Багш хичээл зааж байхдаа нэг байрандаа зогсох биш хөдөлгөөнтэй байх, хүүхдийн хажууд очиж зааж зөвлөх үйлийг дадал болгоорой.
- ➢ Хүүхдийн үйлийн амжилт, алдааг нь буруутгасан өнгө аясгүй, нөхөрсгөөр хэлж өгөөрэй.
- ➢ Хүүхдийн алдааг хэлэхийн өмнө сайн талыг нь заавал хэлж, дараа нь алдааг залруулаарай. Энэ нь хүүхдийн алдаагаа дахин давтахгүй байх, хичээлийн оролцоог нь сайжруулах, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлнэ.
- ➢ Хүүхэд сурах үйлдээ анхаарлаа төвлөрүүлэн **идэвхтэй гүйцэтгэж байгаа үед** нь бяцхан завсарлага хийгээрэй. *(Хэрэв залхсан, уйдсан, ядарсан үед нь завсарлага авбал хүүхдүүд буцаад сурах үйлдээ татагдах нь бага).*

Жишээ 1.

Бага ангийн багшийн ярианаас:

Багш болоод ажлын гараагаа эхлэхдээ миний анзаарсан нэг зүйл бол багшийн хандлага хүүхдийн хичээлийн оролцоо, сурлагын амжилтад нөлөөлдөг хүчин зүйл болохыг мэдэж авсан юм.
Би хичээл эхлэхээс өмнө хүүхдүүдтэйгээ энгийн чөлөөтэй зүйлийг эхлээд асууж ярилцдаг байлаа. Энэ нь одоогийнхоор “мөс хагалах” юм уу даа.

Дараа нь хүүхдүүдээс хичээлийн сэдэв, зорилгоо танилцуулаад энэ хичээлээр юу үзэх бол гэж та нар бодож байна хэмээн асуухад хүүхдүүд янз бүрээр хариулдаг, би заримыг нь самбарт бичдэг байлаа. За одоо тэгвэл юуны тухай болохыг та нар тааж чадсан уу, үгүй юу гэдгийг харцгаая хэмээн хичээлээ заахад хүүхдүүд маш анхааралтай сонсдог. Энэ миний хүүхдүүдийг хичээлд татах нэг арга байсан юм.
Хүүхдүүдийн хичээлийн идэвх оролцоог бий болгохдоо хэрэглэдэг гол арга бол асуулт хариулт буюу хэлэлцүүлгийн арга. Хэзээ ч хүүхдийн хариултыг би буруутгадаггүй за зүйтэй гэдэг ч алдааг нь "чи гэхдээ энэ дээр жаахан алдлаа" хэмээн дараа нь нөхөрсгөөр хэлэхэд хүүхдүүд алдаагаа хүлээн зөвшөөрч дахин алдахгүйн төлөө хичээдэг.

Зөвлөгөө:

- Хичээл эхлэхдээ хүүхдүүдийнхээ анхаарал, сонирхлыг татах ямар нэгэн арга заавал хэрэглээрэй.
- Сэдэлжүүлэх нэг арга бол хүүхдүүдээс асуулт асууж, хариултыг нь урамшуулаарай.
- Хичээлийн зорилго, агуулгаа бүхэлд нь хүүхдүүдэдээ танилцуулаад хичээлээ эхлээрэй.
- Хүүхдийн алдааг хэлэх шаардлагатай бол зөвхөн гаргасан алдааг нь хэлж дараа нь сайн талыг нь хэлээрэй.

Жишээ 2.

6-р ангийн сурагчийн ярианаас

Би бага ангиасаа эхлээд математикийн хичээлдээ дуртай байлаа. Одоо харин сонирхолгүй болсон.
Учир нь намар хичээлдээ орсон эхний үед математикийн хичээл дээрээ самбарт гарч тоо бодсон юм. Гэтэл багш хүүхдүүдээс зөв үү гэж асуухад манай ангийн хэдэн хүүхэд багшаа буруу байнаа гэсэнд, хэн алдааг нь засах вэ гэхэд миний ард суудаг охин гарч ирж алдааг засаж бодсон. За зөв байна. Чи одоо юун дээр алдсанаа ойлгосон уу гээд Н-ийг маш сайн гэж хэлэхэд над огт таалагдаагүй.
Тэр явдлаас хойш би математикийн хичээлд дургүй болж, тоо бодох ч сонирхолгүй болсон. Одоо би хэлний хичээлдээ л шамдъя гэж боддог гэв.

Зөвлөгөө:

- Хүүхэд алдаа гаргасныг хэлэх шаардлагатай бол үе тэнгийнхэн нь хүүхдээр битгий хэлүүлээрэй. Багш та өөрөө тайлбарлаж хэлээрэй.
- Хүүхдийг бусадтай битгий харьцуулаарай.

Суралцагчийн дасан зохицох чадварыг багшлах арга зүйгээр хэрхэн дэмжих вэ?

Багшлах арга зүй гэж юу вэ? Хүүхдэд мэдлэг, чадвар олгох, туслах дэмжих арга хэрэгсэл бүхий багшийн дэс дараалсан үйлийг хэлнэ.

Багшлах арга зүй нь суралцагчдад шинэ мэдлэг, чадвар, туршлага бүтээх, тэдэнтэй харилцах, мэдлэг, чадвар, туршлагыг нь үнэлэх тасралтгүй үйл явц.

Мэдлэг, чадвар, туршлага эзэмшүүлэхдээ дараах үйлийг хэрэгжүүлээрэй.



ЗӨВЛӨМЖ

- Өмнөх хичээлийг сэргээх, давтах, өмнөх агуулгатай холбоотой дасгал ажиллуулах, анхаарал шаардсан дасгал хөдөлгөөн, тоглоомын аргаар хичээл явуулахыг хичээгээрэй. Хичээл дээрээ гүйцэтгэх үйл нь олон янз байх нь суралцагчдын анхаарлыг сарниулдгийг тооцоорой. Суралцагчид дадал төлөвшүүлэх үйлийг аажмаар нэмэгдүүлээрэй.
- Дасан зохицох чадварыг нь дэмжих шаардлагатай, анхаарлаа төвлөрүүлэх нь хангалтгүй гэж ажиглагдсан суралцагчдыг хичээлийн зохион байгуулалт хийхдээ багш өөрийнхөө ойр суулгавал илүү үр дүнтэй байдгийг бодолцоорой.
- Багаар ажиллаж буй тохиолдолд суралцагчдын дасан зохицох чадварыг харгалзаж сурагч бүрийн оролцоог дэмжээрэй.

Жишээ 1.

Асуудал шийдвэрлэх хичээлийн арга зүй

Хичээлийн зохион байгуулалт
Өмнө нь ямар сэдэв үзсэн болон үзсэн агуулгын талаар асуулт асууна. Энд багийн зохион байгуулалт байх нь үр дүнтэй. (хугацаатай, асуулт нь оновчтой цөөн, бататгах чадвартай байх нь зохистой. Асуултаа багш урьчдилан бэлдэнэ. Сугалуулж болох юм. Багийн өрсөлдөөний арга ашиглах нь үр дүнтэй)
Шинэ мэдлэг олгох. Багаар ажиллах боломжтойгоор ширээний зохион байгуулалтыг хийнэ.
Хүүхдүүдийг баг болгож хуваана.

Хичээлийн процесс
А. Тодорхой асуудал шийдвэрлэх даалгаврыг багаар гүйцэтгэнэ. Ямар хэрэглэгдэхүүн ашиглахыг зааж өгнө. Хүүхдүүдийн бүтээлч чадварыг дэмжихэд чиглэнэ. Хүүхдүүдийн жигд оролцоог хангана.
Даалгавар гүйцэтгэх хугацаа 10 минут.
Явцын дунд багш зөвлөн туслах үйлийг гүйцэтгэнэ.
(жишээлбэл,түүхийн хичээл дээр эхийн агуулга дээр эвлүүлэг бүтээвэр хийж болох юм. Нэгдүгээр багийн хүүхдүүд Чингис хааны бага нас болох, Тэмүүжиний хүүхэд насны намтар, 2-р баг залуу нас буюу хаан болсон үеийг, 3-р баг идэр насны үеийг гэх мэтээр эвлүүлэг хийх боломжтой.)

Б. Гүйцэтгэсэн даалгавраа танилцуулна. (жишээлбэл, багаараа гарч ирээд Чингис хааны намтрыг нэг нэгээрээ ээлжлэн ярьж болно.)
В. Мэдлэгээ батжуулна. Хүүхдүүд мэдлэг, мэдээллийн талаар гүн бат ойлголттой болоход чиглэнэ.(жишээлбэл, багш Чингис хааны намтар түүхтэй холбоотой ойлгосон байх ёстой асуултуудыг асууж хүүхдүүд өөрийнхөөрөө дүгнэж ярихад өдөөх нь үр дүнтэй)

Хичээлийн дүгнэлт хэсэг
Хичээлийг хүүхдүүд өөрсдөө дүгнэхэд багш өдөөгөөрэй. Дүгнэлтийн хэсгийн дараа дараагийн үзэх сэдвийг хэлж өгөх нь сэдэлжүүлэх үр дүнтэй байх боломжтой шүү.

Зөвлөгөө:

- Хичээлийн зохион байгуулалтыг багаар хийх, хүүхдүүд чөлөөтэй хөдөлж байх боломжтойгоор хийхэд анхааараарай. Энэ нь хүүхдийн дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой шүү.
- Сургалтдаа бүтээлч идэвхтэй аргыг хэрэглээрэй. Энэ нь хүүхдийн сонирхлыг татахаас гадна тэдний идэвхтэй, бүтээлч чанарыг дэмжих үр дүнтэй.
- Хүүхдүүд даалгавраа гүйцэд дуусаагүй байхад нь богино хугацааны завсарлага авч байх нь үргэлжлүүлэн даалгаврыг хийх сэдэл болдгийг анхааараарай.

Жишээ 2.

Сэтгэхүйг хөгжүүлэх хичээлийн бүтэц

Хичээлийн сэдэв хоорондын залгамж холбоог бий болгох зорилгоор хүүхдүүдээс асуулт асууна. Энэ нь ойлголт, хэрэглээний чадварыг илрүүлэхэд чиглэх

Хичээлийн явцад сэдэвтэй холбоотой асуулт асуух- Эдгээр асуулт нь хүүхдийг гүнзгий сэтгэх, учир шалтгаанд нь сэтгэх чадварыг дэмжсэн. Ингэхдээ өөрийн үгээр хариулах тайлбарлах үйлийг нь дэмжих

Сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэх үйлдлийг дэмжсэн байх- Асуулт нь юмс үзэгдлийн ялгаатай ба төстэй шинжийг олох, нэгтгээд гол шинжээр нь нэрлэх, ямар бүлэг ойлголтод харьяалагдахыг олж хэлэх гэх мэт байж болно.

Юмсыг үнэлж дүгнэх чадварыг дэмжсэн үйл байх- Юмсын үр дагаврт тулгуурлан дүгнэх, юмсын учир шалтгаанд үндэслэн дүгнэлт гаргах логик чадварыг дэмжсэн элементийг оруулж болно.

Зөвлөгөө:

- Хичээлийн элементдээ хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэх элементийг оруулж өгөөрэй. Ингэснээр хүүхдүүдийн учир шалтгаанд нь сэтгэх, юмсын логик зүй тогтлыг олох, бүтцэд нь задлан шинжилж холбоо хамаарлыг таних, ялгаатай ба төстэй, сул ба давуу талыг олох чадвар хөгжинө.
- Асуулт, даалгаврыг гүйцэтгэхэд хүүхдүүдийн жигд оролцоог хангаарай.

*Суралцагчтай **харилцахдаа** дараах зүйлийг хэрэгжүүлээрэй.*

Суралцахуйн амин хөдөлгүүр нь харилцаа юм. Харилцаагүй сургалт гэж нэгээхэн ч үгүй. Юмсын хооронд үүсэж байгаа хэлхээ холбоог харилцаа гэж үзвэл суралцахуйн үйл явцад мэдээлэл, үзэгдэл юмстай харилцах, хүн хоорондын харилцаа, өөртэйгээ харилцах харилцаа бий болдог.

Суралцахуй нь харилцаа юм бол багш энэхүү харилцааг сургалт хөгжлийн үйл ажиллагаандаа оновчтой зохион байгуулах нь багшлахуйн нэг арга техник болно.

Зураг 3. Багш суралцагчтай харилцахдаа дасан зохицолтыг дэмжих арга зам



Нийгмийн орчин, мэдээлэлтэй харилцах

- Сургуулийн орчин, соёл, үйлчилгээ, дүрэм журам, хэм хэмжээ онцлогтой танилцах нь дасан зохицолтын үр дүнтэй арга.
- Хичээлийн хөтөлбөрийн онцлог/судлагдахууны төрөл, гүнзгийрэлт, ач холбогдлыг таниулна.



Хүн хоорондын харилцаа

- Багш нарын онцлог, бага ангийн багшаас ялгаатай тал, ижил тал. Хэрхэн үр дүнтэй харилцаа үүсгэх талаар ойлголт өгөх нь чухал.
- Үе тэнгийн хүүхдүүд хоорондоо хэрхэн харилцах, онцлогийн талаар ойлголт өгнө.
- Харилцааны бэрхшээл үүсэхэд хэнд хандах талаар ойлголт баримжаа өгнө.
- Багш суралцагч бүрийн хувийн онцлогийг таньж харилцах нь чухал.
- Найз нөхдийнх нь дунд суралцагчийн нэр хүндийг эрхэмлэнэ.
- Суралцагчтай ямагт дотно, тэгш харилцаатай байна. *(захиран тушаасан, эсвэл гуйсан аргадсан харилцааны хэв маягаас зайлсхийх, харин санал тавьсан, санаа бодлыг нь сонссон, харилцан ярилцсан хэв маяг оновчтой)*



Өөрийн харилцаа

- Дунд ангид сурах үйлдээ хэрхэн биеэ дааж хандах талаар ойлголт баримжаа өгөх нь чухал.
- Зорилтыг бие даан өөрийнхөөрөө шийдэх чадварыг нь дэмжинэ.
- Өөртөө итгэлтэй зан төлөвийг нь дэмжинэ.
- Өөрийгөө бодитоор үнэлэх чадварыг нь хөгжүүлнэ.
- Сайн талд нь тулгуурлан сул талыг нь засах стратеги баримтална.
- Суралцагчтай хүндэтгэлтэй, ажил хэрэгч харилцааг бий болгох, ингэснээр суралцагч өөрийн тухай зөв ойлголт хандлагатай болох боломжтой.

ЗӨВЛӨМЖ

- Суурь боловсролын 6 дугаар ангид ороход сургуулийн орчин нөхцөлтэй танилцах, сургуулийн үйлчилгээг хэрхэн авах, ямар хүмүүст хандах талаар танилцуулга хийгээрэй.
- Ямар багш нар хичээл заах талаар нэг бүрчлэн албан ёсоор танилцуулаарай.
- Хичээлд ордог багш нар нэгж хичээлийн эхэнд хичээлийн баримтлах дэг дүрэм, судлагдахууны онцлог, түүний ач холбогдлыг *(үр дүнтэй сурах нь ямар ач холбогдолтойг ойлгуулах)* тайлбарлаарай.
- Суралцагчтай харилцахдаа ямагт нүүр рүү нь харж ярианай, ярьж байхдаа буруу харах, өөр юм хийх, дээрээс харилцах зэрэг нь хүүхдийн өөртөө итгэх итгэлийг бууруулж, айдсыг нэмэгдүүлнэ.
- Суралцагчтай ямагт хүндэтгэлтэй харилцсанаар хүүхэд бусдад үнэ цэнтэй хүн гэдгээ мэдэрдгийг анхаарч ажиллаарай. Энэ нь хүүхэд эрхээ хамгаалах чадварт суралцахад чухал нөлөөлтэй байдаг.

- Суралцагч бүртэй багш та эхэлж мэндэлж сураарай. Энэ нь багш нартай нээлттэй харилцах чадвар, хүндлэх мэндлэх ёсонд сургах хамгийн үр дүнтэй арга шүү.
- Суралцагчдад баярлалаа гэж дотноор хэлэх нь үр дүнтэй байдаг. Та туршаад үзээрэй.
- Хичээлийн эхэн үед хүүхдийн алдааг нь онцлохгүй байхыг хичээгээрэй. Гаргаж байгаа алдаа нь дасан зохицож чадаагүй байгаатай холбоотой байж болно. Алдааг онцлоод байх нь хүүхэд сургуулийн орчиндоо айдастай байх, алдаа гаргахаас, багштай харилцахаас айх айдас түгшүүртэй болох төдийгүй өөртөө итгэх итгэл буурдаг.
- Суралцагчийнхаа хувийн онцлогийг ажиглаж таньдаг байгаарай. Боломжтой бол мэргэжлийн сэтгэл зүйн сорил хэрэглэхийг хичээгээрэй.
- Хувийн онцлогийн хувьд, анхаарлаа төвлөрүүлэх чадваргүй сцралцагч байгаа эсэхийг юуны өмнө таниарай. Анхаарлаа төвлөрүүлэх чадвар дутмаг хэт хөдөлгөөнтэй, эсвэл идэвх оролцоогүй байвал ганцаарчлан ажиллах стратеги баримтлаарай. Эс бөгөөс сурлагын хоцрогдолд орох магадал өндөр байдгийг санаарай.
- Суралцагчийн дасан зохицох чадварт нийцүүлэн ганцаарчлан ажиллах , зорилт даалгавар өгөхдөө өөрийг нь ялгаварласан мэт мэдрэмж төрүүлэхгүйн тулд эв дүйтэй хандахыг хичээгээрэй.
- Мөн дасан зохицох чадвар өндөр суралцагчдад ялгаатай даалгавар өгөх тохиолдолд бусдаас давуу гэсэн мэдрэмжийг өөрт нь болон бусдад төрүүлэхгүй байхад анхаараарай.
- Та даалгавар өгсөн бол заавал түүнийг нь үнэлдэг эргэх холбоотой ажиллаарай. Энэ нь суралцагчдад хариуцлагатай зан төлөвийг төлөвшүүлдэг нэг арга юм.
- Та асуулт асуух, заавар өгөхдөө ойлгоогүй байж магадгүй санагдвал давтан хэлэхээсээ бүү цаargалаарай.
- Суралцагчидтай ёс суртахууны төлөвшил, үнэт зүйлийн талаар хэлэлцдэг байгаарай.
- Багш дуу хоолойныхоо өнгө, чанга, сулыг зохистой тохируулахад байнга анхааралтай хандаарай.
- Суралцагчийн эерэг зан төлөвийг урамшуулан дэмжиж байгаагаа илэрхийлдэг байгаарай.

Жишээ 1.

Эерэг харилцаатай багшийн шинж

- Хүүхдийг анхааралтай сонсдог
- Хүүхдийн асуулт, хариулт, даалгаврын гүйцэтгэлд хангалттай цаг хугацаа өгдөг.
- Дахин давтан тайлбарлах ба давтан асуудаг, хариулдаг.
- Хүүхдийг бодитоор урамшуулдаг, магтдаг.
- Хүүхдийн зохисгүйгээр шүүмжилдэггүй, сайн талыг нь олж хардаг.
- Зөв хариулт гүйцэтгэл бүрийг нь урамшуулдаг.
- Олны дунд хүүхдийн сайн талыг нь харуулдаг, алдаршуулдаг.
- Асуултад хариулах боломжийг ямагт олгодог.
- Хүүхэдтэйгээ ойр зайнаас харилцдаг.
- Хүүхэд бүртэй тэгш харилцдаг.
- Дүн үнэлгээ нь шударга
- Хүүхдүүдтэй болон хамт олонтойгоо нөхөрсөг харилцаатай.

- Хүүхдүүдийн амжилт, алдааг нь товч илэрхийлдэг эргэх холбоотой ажилладаг.
- Хүүхдийнхээ нүүр рүү харж харилцдаг, хэл ярианы бус зохистой илэрхийллийг оновчтой хэрэглэдэг.
- Хүүхдүүдэдээ зааварчилгаа сайн өгдөг.
- Хүүхдүүдийн шинэ санал санаачилгыг дэмждэг, өдөөдөг.

Үүний тулд багш та дараах зан төлөвийг хэрэгжүүлээрэй.

- Хүүхдийн ярьж байгаа, асууж байгаа зүйлийг эхнээс нь дуустал нь сонсохыг хичээгээрэй. Хүүхэдтэй ярилцахад цаг гаргадаг байгаарай.
- Хүүхэд ойлгосон эсэхийг ажиглан таньдаг байгаарай. Ойлгоогүй гэж үзвэл эхнээс нь тайлбарлах, эсвэл асуулт асуух, асуултад нь хариулдаг харилцааны стратеги баримтлаарай.
- Дуу хоолойны өнгө нь хэт хурдан, эсвэл хэт удаан, хэт чанга, эсвэл хэт сул биш байхад анхааараарай.
- Хүүхэдтэй харилцахдаа нуруугаа үүрэх, хамраа, чихээ оролдох, алгаа хооронд нь үрэх, гараа урдаа зөрүүлэх, халаасандаа гараа хийх, хуруугаараа заах, доошоо харах, эсвэл хэт дээрээс харах, алгаа доош нь харуулж ярих зэргээс зайлсхийгээрэй. Хэрэв алгаа харуулах үйлдэл хийвэл алгаа дээш нь харуулж яриарай. Энэ нь илэн далангүй байдлын илэрхийлэл. Мөн хүүхэдтэй бага зэрэг бөхийж харилцах нь анхааралтай хандаж байгаагийн илэрхийлэл байдгийг санаарай.
- Хичээл заахдаа самбарын урд байнга зогсохоос зайлсхийгээрэй. Харин дунд нь зогсох, хүүхдийн ширээний хажууд очих, хүүхэдтэй харилцахдаа ойртож очих стратегийг баримтлаарай.

Жишээ 2.

Анхаарлын дутмагшилтай хүүхдийн онцлог

Анхаарлын дутмагшил нь хэт хөдөлгөөнтэй ба идэвхгүй гэсэн 2 хэлбэртэй байдаг. Идэвхгүй хэлбэрийн хүүхдийг хэт дуугүй, хөдөлгөөнгүй, удаан гэж дүгнэх нь бий.

Анхаарлын дутмагшилтай хэт хөдөлгөөнтэй зан төлөвийг 3 төрөлд хуваадаг.
Хайхрамжгүй зан төлөв давамгайлсан
Хэт хөдөлгөөнтэй-цочмог зан төлөв давамгайлсан
Холимог шинжтэй гэж хуваана.

1. ***Хайхрамжгүй зан төлөв давамгайлсан анхаарлын дутмагшилтай хүүхдийн шинж*:**

- ✓ Нүдэн дээр илэрхий зүйлийг ажигладаггүй, хичээл дээр болон өөр бусад үйл ажиллагаанд оролцохдоо анхааралгүй байдлаасаа шалтгаалсан алдаа их гаргадаг.
- ✓ Ямар нэгэн зүйлийг хийх, тоглох зэрэгт анхаарлаа төвлөрүүлэх нь нэн бэрхшээлтэй.
- ✓ Хүний яриаг сонсох чадвар хангалтгүй
- ✓ Зааврыг даган биелүүлэх болон хичээл дээр дасгал даалгавраа дуусгаж чаддаггүй.
- ✓ Ямар нэгэн зүйлийг эмх цэгц дэс дараалалтай хийж чаддаггүй.
- ✓ Бие дааж дасгал даалгавар ажиллах дургүй, байнга зайлсхийж байдаг, хичээл зүтгэл шаардсан зүйл хийхдээ их дурамжхан.
- ✓ Өөрийн юмаа их алдаж, гээдэг. Хичээлийн хэрэглэл, тоглоом гэх мэт
- ✓ Гадаад орчны нөлөөлөлд анхаарал нь амархан сарнидаг.
- ✓ Их мартамхай байдал ажиглагддаг.

Анхаарлын дутмагшилтай хэт хөдөлгөөнтэй хүүхдэд дээр дурдсан шинжүүдээс хамгийн доод тал нь 6 шинж ажиглагдаж хөгжилд нь сөргөөр нөлөөлдөг байна.

2. Хэт хөдөлгөөнтэй хүүхдийн шинж:

- ✓ Гар хөл нь байнгын хөдөлгөөнтэй, суудал дээрээ тогтвортой суудаггүй
- ✓ Ангидаа байнга л босож явах дуртай.
- ✓ Орчин нөхцөл нь зохимжгүй байсан ч байнга л гүйж, харайж байдаг. (жишээ нь, ангидаа, олон нийтийн газар, танихгүй айлд гэх мэт)
- ✓ Амралт чөлөөт цагаа зөв өнгөрөөх чадвар сул
- ✓ Байнга л "зүгээр бай" томоотой бай" гэх мэтээр шаардуулж байдаг.
- ✓ Байнгын л ярьж байна.

3. Цочмог зан төлөвтэй хүүхдийн шинж:

- ✓ Асууж дуусаагүй байхад л хагас дутуу хариулдаг.
- ✓ Ээлж дараалал хүлээх нь их хэцүү байна.
- ✓ Бусдын яриа, тоглоом, үйлдэл зэргийг байнга тасалдуулдаг.

(*Эдгээр шинжүүд нь хамгийн багадаа 6 сарын турш ажиглагдаж хөгжил төлөвшилд нь сөргөөр нөлөөлж байвал анхаарлын дутмагшлын тухайн шинж илэрч байна гэж үзнэ)*

Зөвлөгөө:

Идэвхгүй ба хайхрамжгүй хэт идэвхтэй анхаарлын дутмагшил ажиглагдаж байгаа хүүхэдтэй харилцахдаа:

- Дотно тайван харилцаарай. Эс бөгөөс хүүхэд амархан айдаст автагдах нь бий.
- Хүүхдийн анхаарлыг нь сайжруулахын тулд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, ялангуяа, урлаг уран сайхны үйл ажиллагаанд татан оролцуулах нь анхаарлыг сайжруулах үр дүнтэй.
- Хичээл дээр ойрхон завсарлага авч амраах үйлийг хийгээрэй. Гэхдээ дасгал даалгавар дууссан биш дуусаагүй үед нь завсарлага хийгээрэй.
- Хичээл дээр ганцаарчлан ажиллах стратеги баримтлаарай.
- Заавар болон асуултыг давтан асуухаас битгий түвэгшээгээрэй.
- Алдааг нь битгий онцлоорой.

Хэт хөдөлгөөнтэй хүүхэдтэй харилцахдаа:

- Хүүхдийг хичээл дээр байрандаа зөв суухыг сануулаарай.
- Сургуулийн дотоод дэг журамд захирагдах ёстойг нь ойлгуулаарай.
- Аль болох багш өөртөө ойр суулгаарай.
- Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох идэвхийг нь дэмжээрэй.
- Хүсэл, авьяас сонирхлыг нь таньж мэдсэний үндсэн дээр спорт, урлаг, уран сайхны дугуйланд хамрагдахад нь дэмжээрэй.
- Багш өөрт нь болон бусад хүүхдүүдэд туслах ямар нэгэн үүрэг оноох нь үр дүнтэй байдгийг санаарай

Цочмог зан төлөвтэй хүүхэдтэй харилцахдаа:

- Асуултыг гүйцэд сонсож сурахыг аажмаар дадал болгохыг хичээгээрэй.
- Асуултад хариулах, юм асуухдаа гараа өргөх эсвэл зөвшөөрөл аваарай гэдгийг дадал болгоорой
- Анхааралтай ойлгож сонсож сургах, ойлголтыг нь асуух, хариултыг нь залруулах ба дахин хариулах зэргийг санал болгож байгаарай.
- Тухайн хүүхэд гүйцэтгэж чадахуйц цөөн тооны, хялбар дасгал даалгаврыг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэхэд анхааараарай. Гэхдээ хэт яарсан байдалд бүү оруулаарай.
- Өөрийг нь онцолсон, үйлдлийг нь байнга анхаарсан мэт сэтгэгдэл төрүүлэхгүй байхыг хичээгээрэй.
- Сэтгэл санаагаа тайван байлгах тал дээр нь ажиллаарай.
- Хүүхэдтэй нөхөрсөг ажил хэрэгч харилцааг бүрдүүлээрэй.

Суралцагчийн дасан зохицох чадварыг үнэлгээгээр хэрхэн хөгжүүлэх вэ?

Хичээлийн үнэлгээ нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага, ахиц дэвшил, цаашид сурах чадвар, буюу сурах хэрэгцээ шаардлага зэргийг үнэлэх янз бүрийн арга хэрэгсэл юм.

Хичээлийн явцад хүүхдийг үнэлэхдээ албан ёсны стандарт арга хэрэгслийг ашиглахаас гадна багш хичээлийн явцад хүүхдийн хөгжлийг үнэлэх, хэрэгцээг тодорхойлох үүднээс явцын үнэлгээний арга хэрэгслийг ашиглах нь үр дүнтэй байдаг.



ЗӨВЛӨМЖ

- Үнэлгээг хичээл бүр дээр хийж байх нь үр дүнтэй.
- Үнэлгээ хийхдээ багш нар хүүхдүүдийг хооронд нь харьцуулсан, хувийн өрсөлдөөнийг бий болгохгүй байхыг хичээгээрэй.
- Үгэн урамшуулал хэрэглэхдээ бүх хүүхдийг “сайн байна”, “маш сайн”, гэх мэтээр ялгаагүй урамшуулах биш, харин яг гүйцэтгэлийг нь давуу талыг нь мэдрүүлж ялгаатай урамшуулаарай.
- Зөвлөж үнэлэх аргыг хэрэглээрэй.Тухайлбал, *хүүхдийн ярьсан зүйлийг урамшуулахдаа бага зэрэг засаж хэлэх, жишээлбэл, тойрог гэж юу вэ гэж асуухад хүүхэд бүх хэсэг нь өнцөггүй дүрс гэж хариулвал, тиймээ өнцөггүй дүрс гэдэг нь зөв сайн байна, тэгэхээр төвөөс ижил зайд алслагдсан цэгүүдийн холбоос байж болох байна* гэх мэтээр тайлбарлаж ойлгуулж болох юм.
- Үнэлгээг бичгээр хийхдээ тухайн хичээлээс ойлгосон, сурч мэдсэн зүйлээр 5 мөрт зохиох, оюуны зураглал хийх гэх мэт бүтээлч сургалтын аргуудыг ашиглаж үнэлээрэй.
- Мөн бичгээр үнэлгээг хийхдээ энэ хичээл дээр юуг ойлгоход хэцүү, хялбар байсныг асуух нь хүүхэд хичээлийн үйл явцыг эргэцүүлэн бодох, дараагийн удаа хичээлдээ анхаарах сэдэл өгөх, багш заах арга зүйгээ сайжруулах гэх мэт давуу талтай.
- Тухайн мэдлэгийг хэрэглэх боломжийн талаар асуултдаа оруулж болно.
- Үнэлгээг ганцаарчлан болон бүлгээр хийж болно.

Дасан зохицох чадварыг хөгжүүлэхэд *өөрийн үнэлгээг* ашиглах нь тустай.

Жишээ 1.

Багш та дараах ажиглалтын хуудсыг ашиглан суралцагчдаа үнэлээрэй.

Шалгуур	Хөгжүүлэх шардлагатай	Дунд зэрэг	Хангалттай сайн	Цаашид дэмжих зүйл
Анхаарлаа төвлөрүүлэх чадвар				
Сэтгэн бодох чадвар				
Дүгнэлт гаргах чадвар				

Санаа бодлоо ойлгомжтой илэрхийлэх чадвар				
Өөртөө итгэлтэй зан төлөв				
Бие даасан байдал				
Хичээлийн идэвх				
Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, нийцтэй зан төлөв				
Хичээлийн үед дүрэм, заваар баримтлах				
Багаар ажиллах чадвар				
Зөвлөгөө: - Нэг хичээл дээр бүгдийг нь биш цөөн цөөнөөр нь үнэлбэл илүү бодитой болно. - Заавал бүх шалгуур үзүүлэлтийг оруулахгүйгээр цөөн цөөнөөр нь үнэлж болох юм. - Заримт тохиолдолд багш танд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн шалгууруар үнэлэх боломжтой шүү. Энэ нь хичээл судлагдахууны зорилгооос хамаарч болно. - Тухайн үнэлгээг зөвхөн хичээл бус бусад хөгжүүлэх үйл ажиллагаанд ч хэрэглэх боломжтой. - Үнэлгээний үр дүнг цаашид хүүхэдтэй харилцах, хичээл, хөгжлийн бусад үйл ажиллагааг төлөвлөхөд харгалзаарай.				

Жишээ 2.

Өөрийн үнэлгээ хийцгээе, хүүхдүүдээ

Асуулт	 Сэтгэл дундуур	 Сэтгэл ханамж дунд	 Сэтгэл хангалуун
Өнөөдөр хичээлээ ойлгосон эсэхээ үнэлээрэй.			
Өнөөдөр хичээлдээ идэвхтэй оролцож чадсан уу?			
Өөртөө итгэлтэй байж чадсан уу?			
Дасгал даалгавраа цаг хугацаанд нь анхаарлаа төвлөрүүлэн хийж чадсан уу?			
Ангийн хүүхдүүдтэйгээ нийцтэй, эерэг харилцаатай байж чадсан уу?			
Өөрийгөө ойлгомжтойгоор илэрхийлж чадсан уу			

Өөрийн давуу, сайн талаа мэдэрч чадав уу			
Өөрийн сул талаа ойлгож, сайжруулах санаагаа олж авсан уу			

Зөвлөгөө:

- Үнэлгээг шударга хийхийг хүүхдүүдэд зөвлөөрэй.
- Хичээл дээр ийм үнэлгээ тогмол хийхийг сануулаарай
- Үнэлгээ хийхэд зарцуулах цагаа оновчтой төлөвлөөрэй.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу?

Суралцагчдын сонирхлыг төрүүлэх, сонирхолд нь нийцсэн авьяас чадварыг хөгжүүлэх, “зөөлөн ур чадвар” буюу мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөн, харилцааны чадварын төлөвшилтөд дэмжлэг бүхий үйл ажиллагааны олон төрлийг хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэнэ. Энэ нь спорт, урлаг, бүтээл туурвилын дугуйлан секц, сайн дурын үйл ажиллагаа, нийгмийн туст хөдөлмөр гэх мэт олон талын үйл ажиллагаа байж болно.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд суралцагчид жигд оролцоотой байснаар идэвх сонирхол нь хөгжих, мэдлэг чадвар нь нэмэгдэх, өөрийн үнэлэмж сайжрах, хамтын үйл ажиллагаа бий болох зэрэг нь дасан зохицолтыг сайжруулах гол арга зам юм.



ЗӨВЛӨМЖ

- Суралцагч бүрийн авьяас сонирхлыг ажиглан таньж, тохирсон секц, дугуйланд хамрагдах санал тавьж дэмжээрэй.
- Суралцагч бүрийг төлөвлөгөөт урлаг, уран сайхны үйл ажиллагаа, спортын арга хэмжээнд жигд оролцуулах нь тэдэнд хариуцлагатай, идэвхтэй, нөхөрсөг, хамтач, өөртөө итгэлтэй, мэдрэмжтэй зан төлөв, чадвар дадал эзэмших, сонирхлыг төрүүлэхээс гадна бие бялдрын хөгжлийг нь дэмжих ач холбогдолтой.
- Хичээлийн агуулгыг өргөжүүлэх болон танин мэдэхүйн хөгжлийг дэмжих зорилгоор үзвэр үзэх, аялал зугаалга хийх зэрэг төрөл бүрийн арга хэмжээг үйл ажиллагаандаа төлөвлөн хэрэгжүүлээрэй. Энэ нь суралцагчийн сэтгэлийн хөдөлгөөний мэдрэмж, идэвх, хариуцлага, сонирхол, хамтач зан төлөвийг нэн тэргүүнд хөгжүүлэх чухал нөлөөтэй.
- Хичээлээс гадуурх төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа суралцагчийн өөрийн идэвх санаачилга дээр тулгуурлах, хувийн онцлогийг нь харгалзан үзэж хүндэтгэлтэй харилцааг эрхэмлэх нь үр дүнтэй байдаг.

- Аливаа асуудлыг баг болон хэлэлцэх, санаа бодлоо илэрхийлэн шийддэг буюу нэг шийдэл ойлголцолд хүрдэг үйл ажиллагааг ангидаа хэвшил болгоорой.
- Суралцагчийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоог урамшуулах аргуудаас хэрэглээрэй.
- Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран өөрийгөө бие даан хөгжүүлэх арга зам, ач тус, сэтгэл санааны тайван байдлаа хадгалах аргын талаар зөвлөгөө, сургалт гэх мэт олон талын үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлээрэй.
- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулаарай.
- Хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулахдаа аж ахуйн нэгж байгууллагатай хамтрах стратегийг баримтлаарай.

Жишээ 1.

7-р ангийн хүүгийн ээжийн ярианаас

Миний хүү уг нь их сэргэлэн, зөөлөн, нийтэч, тусархуу зантай. Их хөдөлгөөнтэй боловч хичээл дээр энэ байдал нь ажиглагддаггүй харин эсрэгээрээ их “томоотой” гэж багш нар ярьдаг.
Хүүгийн маань сонирхол нь дуу дуулах, дуу сонсох. Ер нь хичээлээ удаан ойлгодог, бас тийм ч сонирхолтой биш.
Харин урлагийн үзлэгт оролцох, жүжиглэх их дуртай. Дуу хөгжмийн багш нь ангид нь орж ирээд дууны дугуйланд орох сонирхолтой хүүхдүүдийг ангийн багштай нь ярилцаж байгаад сонгоход миний хүү саналаа хэлсэн ч “чи дэмий” гэж хэлээд авсангүй гэж их гунигтай ирсэн. Түүнээс хойш урлагийн үзлэгтээ оролц гэхэд их л дургүйцэн бухимдаж шууд татгалздаг болсон. Хичээлдээ улам л дургүй болсон. Арга ядаад одоо өөр сургуульд шилжүүлсэн. Гэтэл энэ байдал нь засрахгүй л байна. Багш нар сонирхлоор нь хүүхдийг дэмждэг л баймаар байна.

Зөвлөгөө:

- Хүүхдийн давуу талд тулгуурлан танин мэдэхүй, нийгэмшлийн чадварыг нь дэмжээрэй.
- Хүүхдийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоог дэмжихдээ бусад мэргэжлийн багш нартай хамтарч ажиллаарай.
- Хүүхдийн хүсэл сонирхлыг нь дэмжин хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан эерэг зан төлөв, сургуульдаа хандах эерэг хандлагыг дэмжих боломжтой.

Жишээ 2

БСУХ, “Монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлог” судалгааны үр дүнгээс

Өсвөр насны хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадварын хөгжилд хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо нь тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлдөг нь статистик ач холбогдлын түвшинд харагдлаа ($p<0.01$).
Хүүхдүүд спортын үйл ажиллагаанд оролцоо идэвхтэй байх нь биеийн өсөлт, хөгжил ялангуяа биеийн жин, өндөр, булчингийн хүч зэрэг бие бялдрын хөгжил мөн богино хугацаанд харж мэдээлэл тогтоох болон анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах чадварыг нь дэмжих үр дүнтэй байна.

Спортын арга хэмжээ болон урлагийн үзлэгт ордог хүүхдүүдийн нийгэмшлийн чадвар нь оролцдоггүй хүүхдүүдээс илүү эерэг байлаа. Ялангуяа, урлагийн үзлэгт оролцдог хүүхдүүд бусадтай харилцах, бусдыг ойлгож дотно хандах, айдас түгшүүр багатай өөдрөг байдаг бол спортын уралдаан тэмцээнд оролцдог хүүхдүүд илүү өөртөө итгэлтэй, зан төлөвөө удирдах чадвар нь эерэг байх магадлал өндөр байна.
Иймд эцэг эх, асран хамгаалагчид, сургуулийн зүгээс спортын уралдаан тэмцээн, бусад урлаг соёлын үйл ажиллагааны жигд оролцоог хангах нь цогц хөгжлийг дэмжих нэг арга зам болдог нь судалгаанаас харагдлаа.

Зөвлөгөө:

- Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үндэс болдог анхаарлын төвлөрөл, мэдээллийг тогтоох ойн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой тул ялангуяа анхаарал, ой тогтоолт сул ажиглагдаж байгаа хүүхдүүдийн оролцоог онцгойлон дэмжээрэй. Жишээлбэл, хөдөлгөөнтэй анхаарал төвлөрөл сул хүүхдийг хөл бөмбөгийн секцэд хамруулах нь өндөр үр дүнтэй байдаг..
- Урлаг, спортын үйл ажиллагаа нь хүүхдийн тархины үйл ажиллагааг идэвхжүүлэх, баяр баясгалан урам зориг төрүүлэх нөлөөтэй тул хөгжлийн гол хүчин зүйл болдог гэдгийг санаарай.

Багш эцэг эх, асран хамгаалагчтай хамтран суралцагчдын дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу?

Суралцагчийн эцэг эхийн хэрэгцээ, хүлээлттэй уялдсан боловсролын үйлчилгээ, чанар, үр дүнг бий болгох нь салбарын нэг асуудал юм. Үүний тулд олон улсад сургууль ба эцэг эхчүүдийн хамтын оролцоо бүхий сургалт хөгжлийн үйл ажиллагааны соёлыг чухалчилдаг туршлага байдаг.

Суралцагчийг амьдралд бэлтгэх зорилгынхоо хүрээнд боловсролын салбар нь нийгэм, суралцагчдад төдийгүй эцэг эхчүүдэд хүлээлтийг бий болгодог. Хүлээлтийг хангаж чадаж байна уу, үгүй юу гэдгээр боловсролын чанарыг хэмжиж болдог. Хэдийгээр анги дэвших тусам эцэг, эхийн шууд оролцоо багасдаг хэдий ч тэдний зохистой оролцоо нь ялангуяа өсвөр насанд сургуулийн орчинд дасан зохицоход үр нөлөөтэй байдаг.

Суралцагчдын хөгжил, сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд сургуулийн менежмент, суралцахуйн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн дуу хоолойг сонсох нь зөв менежментийн арга хэмээн улс орнууд үүнд анхаардаг боллоо.

Эцэг эх, асран хамгаалагчид сургалт хөгжлийн үйл ажиллагаанд зүгээр л оролцох нь “бодит оролцоо” биш бөгөөд үүнд эерэг хандлага, үүрэг хариуцлагатай мэдрэмж, сайн дурын идэвх оролцоо нь гол шалгуур юм.

Суралцагчийн дасан зохицох чадварыг дэмжихдээ сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааг бий болгох гаргалгаа нь нэгдүгээрт, сургууль ангийн үйл ажиллагаанд эцэг эхийн дуу хоолойг сонсох, хоёрдугаарт, эцэг эх, асран хамгаалагч ба хүүхэд хоорондын харилцаа хандлагыг сайжруулахад зөвлөн туслах, гуравдугаарт, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх юм.



ЗӨВЛӨМЖ

- Дунд ангид элсэн суралцсанаар сургалтын орчин хэрхэн өөрчлөгдөх болон энэ нь суралцагчдад ямар нөлөө үзүүлэх талаар 5-6 дугаар ангийн хүүхдийн эцэг эхчүүдэд таниулан сурталчлаарай.
- Хүүхдээ хэрхэн хөгжүүлэх хэрэгцээ, хүсэл эрмэлзлэлийнх нь талаар эцэг эхчүүдийн “дуу хоолойг сонсох”-ыг эрхэм болгож хэрэгжүүлэх бодит боломжийн талаар ярилцдаг байгаарай.
- Анги, сургуулийн үйл ажиллагаанд оролцох нь суралцагчийн хөгжилд ямар ач холбогдолтойг ойлгуулан хамтарч ажилладаг байгаарай.
- Сургуулийн хүрээний үйл ажиллагааны талаар эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг, мэдээллийг дэмжээрэй.
- Хүүхдийнхээ сурах үйлийг дэмжих эцэг эх, асран хамгаалагчдын чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлээрэй.
- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ хичээлд суух боломжийг олгоорой.
- Эцэг эх, асран хамгаалагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд нь тулгуурлан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг байгаарай.
- Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөгөө уулзалтыг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлээрэй.
- Хүүхэдтэй харилцах дэвтрийг хэрэглэн үр дүнг нь туршиж үзээрэй.

Жишээ 1.

Судалгааны үр дүнгээс

Эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа (үйлчилгээ, аюулгүй байдал, заах ур чадвар, сургалтын чанар, эцэг эхийн оролцооны талаар) авч мэдээллийн сан бүрдүүлдэг туршлага Бразил улсад байна (Barbara Bruns, Deon Filmer, Harry Anthony Patrinos., 2011). Эцэг эх, асран хамгаалагчдын 55.8 хувь нь хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийхэд “хааяа”тусалдаг бол 14.7 хувь нь л “байнга” тусалдаг байна. “Завгүй” эсвэл “хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чадахгүй” гэсэн хариулт 29.6 хувийг эзэлж байна. Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд байнга тусалж дэмждэг эцэг эх, асран хамгаалагчид сурлагын ахиц өөрчлөлтийн талаар багштай нь байнга ярилцдаг байна. Харин завгүй эсвэл хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй эцэг эх хүүхдүүдийнхээ сурлагын ахиц өөрчлөлтийн талаар байнга ярьдаг нь цөөн хувьтай гэжээ. Эцэг эх, асран хамгаалагчдын 62.2 хувь нь хүүхдийнхээ багштай байнга уулздаг байна. (Хүүхдийг ивээх сан , 2018)

Судалгаанд эцэг эх нь таагүй ханддаг гэж хариулсан хүүхэд, залуучуудын өөрийгөө хүлээн зөвшөөрөх чадвар нь таатай ханддаг гэж үзсэн хүүхэд, залуучуудаас сул байсан байна. Өсвөр насны хүүхдүүдийн хувьд үүнээс гадна таагүй ханддаг гэж үзсэн хүүхдүүдийн бусадтай хамтрах, нээлттэй харилцах чадвар нь эцэг эх нь байнга урамшуулдаг гэж үзсэн үе тэнгийхнээсээ сул байгаа нь харагдсан. Аваасаа мэдэхгүй зүйлээ асууж ярилцдаг хүүхдүүдийн нээлттэй зан төлөв харилцаа багатай хүүхдүүдээс харьцангуй сайн байсан байна. Иймд эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхэдтэйгээ нээлттэй идэвхтэй харилцах чадварыг нь дэмжсэн арга зүйн дэмжлэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах хэрэгцээ байна (Боловсролын хүрээлэн , 2018).

Эцэг эхтэйгээ хамт зугаалдаг, аялалаар явдаг, гэрийн даалгавар, гэрийн ажлыг хамт хийдэг сурагчдын сурлагын амжилт нь эцэг эхтэй харилцаа хангалтгүй суралцагчдаас өндөр байсныг судалгааны үр дүнд дурдсан байна (БҮТ, 2015, 2018).

Зөвлөгөө:

- Эцэг эх, асран хамгаалагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд тулгуурлан үйл ажиллагааг тэдэнтэй хамтран төлөвлөхийг “соёл” болгон төлөвшүүлээрэй.
- Хүүхдүүдийнхээ гэрийн даалгавар хийхэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн аргачлал, зөвлөмжийг өгөөрэй.
- Хүүхдээ ойлгож, дотно харилцах талаар эцэг эхчүүдэд, тэрчлэн ээж аав, гэр бүлийнхэнтэйгээ хүндэтгэн дотно харилцах талаар суралцагчдад мэдээлэл мэдлэг олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг байгаарай.
- Өсвөр насны хүүхдийг гэр бүлийн орчинд хэрхэн дэмжих талаарх мэргэжлийн хүний зөвлөгөө, туслан дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах нь үр дүнтэй байдаг.

Жишээ 2.

Нэгэн аавын ярианаас

Охин маань 5-р ангид сурдаг. Эцэг эхчүүдийн дунд зохиогддог нэгэн төрлийн ажил нь эцэг эхчүүдийн дунд зохион байгуулдаг спортын арга хэмжээ юм. Эцэг эхчүүдийн хооронд тэмцээн уралдаан болдог.

Миний бодлоор энэхүү үйл ажиллагаа нь эцэг эхчүүдийг хооронд нь танилцуулдаг юм шиг. Өөр ач холбогдлыг би олж хардаггүй тул надад энэ нь дарамттай санагддаг. Дараа нь эцэг эхчүүд, зарим тохиолдолд багш нартай нь хамтдаа баранд орох, караокедох гэх мэт сунжирсан үйл ажиллагаа болох нь их. Үүний дараа нэг аав шөнө дунд согтуу гэртээ очиж эхнэр хүүхдээ зовоосон тохиолдлыг охин маань надад ярьсан нь их гунигтай санагдаж билээ.

Би залуу хүн тул тэмцээнд нь оролцдог, гэтэл ээж аавгүй, тэднээсээ хол амьдардаг, эмээ өвөөтэйгээ цуг байдаг цаашилбал, хожуу хүүхэдтэй болсон гэр бүл оролцох боломж хязгаарлагдмал, зарим ээж аавууд оролцох чадваргүй байх нь ч бий. Энэ тохиолдолд хүүхдэд “ялгаатай байдал” бий болж эвгүй байдалд орох, сэтгэл санааны дарамтад орж болно шүү дээ. Ийм байдлыг харгалзан, миний хүүхдийн хөгжилд үнэхээр ач холбогдолтой зүйлд л эцэг эхчүүдийг оролцуулж баймаар байна.

Зөвлөгөө:

- Эцэг эх, асран хамгаалагчдын дунд үйл ажиллагаа зохион байгуулахдаа ач холбогдол нөлөөллийг нь заавал тооцож үздэг байгаарай.
- Эцэг эх, асран хамгаалагчдын үйл ажиллагааны оролцоо нь хүүхдийн сэтгэл зүйд хэрхэн нөлөөлөх талаар бодолцоорой..
- Хамтын үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчид жигд оролцох, тэдний санаа бодлыг ил тод сонсож шийдвэр гаргалтдаа харгалздаг байгаарай.
- Ямар ч үйл ажиллагаа нь эцэг эх, асран хамгаалагчид, гэр бүлийн нэр хүндийг эрхэмлэсэн байхад анхаараарай.

Жишээ 3.

Германд амьдардаг эзжийн ярианаас

Миний хүү 5-р ангид ангид сурдаг. Тухайн сургуулийн эцэг эхтэй ажилладаг зарчим нь: эцэг эхчүүдэд дарамт болохгүй байх, хүндэтгэлтэй хандах юм шиг санагддаг. Эцэг эхийн уулзалт нь 2 төрлийн байна.

Нэгдүгээрт нь хичээлийн жилийн эхэнд багш нь эцэг эхийн хурал хийж, тухайн жилд орох судлагдахуун,зохиогдох төлөвлөгөөт үйл ажиллагаа, түүний зорилго, хичээл явагдах арга зүй, эцэг эхийн туслалцаа дэмжлэг, хүүхдэд тавигдах шаардлагын талаар танилцуулга хийнэ. Хоёрдугаарт нь, хичээлийн жилийн явцад эсвэл улирал дуусахад эцэг эхийн уулзалт хийнэ. Үүнийгээ эхнээсээ төлөвлөн, 1-2 сарын өмнө эцэг эхчүүдэд “харилцах дэвтэр”-ээр дамжуулан захиа бичнэ. Үүнд: уулзалтын зорилго, ирэх боломжтой цаг хугацааг нь асуудаг. Эцэг эхчүүд уулзах боломжтой цаг хугацаагаа бичиж явуулахад уулзалтын хуваарь гарган, тухайн хуваарийг явуулдаг.

Энэ уулзалт нь зайлшгүй хэлэх шаардлагатай зүйлийг л хэлнэ. Мөн эцэг эхийн ажиглалт, тайлбар, санаа бодлыг анхааралтай сонсож, зөвлөгөө өгдөг. Гэхдээ хэзээ ч эцэг эхийн санааг бууутгадаггүй. Хэрэв хүүхдэд нь асуудал бага бол цагийг нь үрэхгүйгээр уулзалтаа дуусгадаг. Энэ нь ямар хичээлдээ анхаарах шаардлагатай, яаж дэмжих, хүүхдийн төлөвшил зан төлөв, дадал, эрүүл мэндийн байдал зэргийг нь хамарна.

Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг оролцуулахдаа саналыг нь сонсож төлөвлөдөг. Жишээлбэл, 5 дахь өдөр хүүхдүүдийг дугуй унахад сургах ажил байж болно. Энэ тохиолдолд туслах боломжтой эцэг эх байгаа эсэхийг хурал уулзалтаас асууж тодруулаад төлөвлөгөөндөө тусгана. Тэр өдөр боломжтой эцэг эхчүүд нь хүүхдүүдийг дугуй унаж сурахад туслах, аюулгүй байдлаа хангах, хөдөлгөөнд оролцох дүрмийн талаар заана. Зарим эцэг эх гэртээ зууш хоол бэлдэж хүүхдүүдэд өгдөг.

Мөн эцэг эхчүүд өөрсдийнхөө ажилладаг газартай танилцуулах гэх мэт ажлыг зохион байгуулах нь элбэг байдаг.

Өөр нэг чухал туршлага бол жилд тодорхой хэмжээний мөнгийг хуримтлалын санд өгдөг. Энэ нь албан ёсны нэрийн данс байдаг. Тухайн хуримтлалыг хүүхэд хөгжлийн үйл ажиллагаандаа зарцуулдаг ба тухайн тохиолдолд зарцуулалтыг албан ёсоор тайлагнадаг.

Зөвлөгөө

- Эцэг эхчүүдтйн харилцах дэвтэр гаргах талаар бодолцож үзээрэй.
- Эцэг эхчүүдийн давуу талыг нь харгалзан хичээлээс гадуурх үйл ажиллагааг төлөвлөөрэй.
- Эцэг эхийн уулзалтыг бөөнд нь биш, ганцаарчлан уулзах талаар төлөвлөөрэй. Энэ тохиолдолд уулзалтын хуваарь гарган цагийг нарийн төлөвлөөрэй.

Сургуулийн хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бага ангиас дунд ангид шилжин суралцах үеийн суралцагчдын дасан зохицох чадварыг хэрхэн тусгах вэ?

Хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг нь хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжлийг дэмжих зорилготой хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилсан төлөвлөлт юм.

5-6 дугаар ангийн хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь:

- Өөртөө итгэх итгэлийг нь дэмжих
- Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, бие даан өөрийн зан төлөв, үйл ажиллагаагаа удирдан зохицуулах чадварыг төлөвшүүлэх
- Сэтгэл санааны тогтвортой байдлаа хадгалж стрессээ зохицуулах аргад сургах
- Үйл ажиллагааны идэвхтэй оролцоо, сонирхлыг төрүүлэх
- Анхаарлаа төвлөрүүлэх, мэдээллийг тогтоох чадварыг нь дэмжих
- Бие бялдрын уян хатан, тэнцвэрт, тэсвэртэй, хурдтай байх чадварыг дэмжсэн үйл ажиллагааг багтаах нь зохимжтой.



ЗӨВЛӨМЖ

- Суралцагчийн сурах чадвар, эерэг төлөвшил, биеийн өсөлт хөгжлийг дэмжих үйлийг тусгаарай.
- Хөгжлийн төлөвлөгөөгөө тодорхой шалгуур, зорилго, үр дүнгийн үзүүлэлт, хэрэгжүүлэх арга хэмжээ, арга хэрэгсэл гэсэн бүтэцтэй боловсруулахыг хичээгээрэй.
- Үйл ажиллагааны төлөвлөлтийн зорилго нь бодитой, хэмжигдэхүйц байх нь үр дүнтэй.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хүүхэд бүрийн оролцоог хангасан, олон талт байхад анхааараарай.
- Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцдог байгаарай.
- Хөгжлийн төлөвлөгөөний үр дүнд тулгуурлан дараагийн үйл ажиллагааг төлөвлөдөг эргэх холбооны механизмыг хэрэглээрэй.
- Хэрэгжүүлэх арга хэмжээний зохион байгуулалт арга хэрэгсэл нь өмнөх үйл ажиллагааны үр дүнд үндэслэн боловсронгуй болох уян хатан байхад анхааараарай.
- Хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад хүүхдийн оролцоог хангахад анхаарч ажиллахыг хичээрэй.


Багш нарын хамтын ажиллагаагаар хүүхдийн дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу?

Багшийн хамтын үйл ажиллагаа нь сургалтын байгууллагын үйл ажиллагааны чанарыг илэрхийлэх гол үзүүлэлт байдаг. Багш нар хамтарч ажилладаг соёл сайтай бол мэргэжлийн ур чадварын өсөлт, харилцаа, сэтгэл санааны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхээс гадна суралцагчдын хөгжил төлөвшилд үр дүнгээ өгдөг.

Багшийн хамтын ажиллагааны нэг хэлбэр нь “Мэргэжлийн хөгжлийн бүлэг” (МХБ) бөгөөд тухайн үйл ажиллагааны чиглэлд багш нар 5-6 дугаар ангийн суралцагчийн дасан зохицолтыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллаж, харилцан туршлага солилцох арга зүйг тогтмолжуулж болох юм.

Сургуулийн 5-6 дугаар ангид хичээл ордог болон ангийн багш нар, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, удирдах ажилтнууд хоорондоо суралцагчийн дасан зохицолтыг дэмжих тал дээр хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг механизмыг бий болгох нь ач холбогдолтой.

Зураг 4. Багш нар суралцагчийн дасан зохицолтыг хангах арга



ЗӨВЛӨМЖ

- 6 дугаар ангид багш нар хамтарч хичээлээ төлөвлөж заах нь үр дүнтэй ба тухайн хичээл нь багийн ажил, туршилт хийх гэх мэт хүүхдэд сурах арга барилыг эзэмшүүлэхэд чиглэсэн байх нь үр дүнтэй.
- 5-6 дугаар ангийн суралцагчдын сурах үйл явцыг сайжруулах, тэдэнд тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэхэд анги даасан багш болон хичээл ордог багш нар мэргэжлийн хөгжлийн бүлгийг үүсгэж туршлага солилцон хамтран ажиллаарай.
- 5-6 дугаар ангийн суралцагчдын сурах арга барил, суралцахуйн онцлог, хөгжил төлөвшлийн талаар хамтран туршлага солилцох сургалт семинарыг зохион байгуулах нь үр дүнтэй.
- 5 дугаар ангийн суралцагчдад дунд ангид дэвшин суралцахад хичээл орох багш нар, судлагдахууны талаар сонирхолтой танилцуулга зохион байгуулаарай.
- 6 дугаар ангид дэвшин суралцаж байгаа үед суралцагчдад сургалт хөгжлийн үйл ажиллагааны талаар хамтран танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулах нь дасан зохицолтыг сайжруулах нэг арга юм.

- 5-6 дугаар ангийн хүүхдүүдэд үүсээд байгаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдэх талаар мэргэжлийн бүлэг дотроо харилцан ярилцаж хамтран шийддэг байгаарай.
- Дунд ангид элсэн суралцаж байгаа хүүхдүүдийн хүсэл сонирхол, сурах чадвар болон бие даах чадвар, идэвх хариуцлагатай зан төлөвийг дэмжих үүднээс мэргэжлийн бүлгийн багш хамтран нар өсвөрийн төрөл бүрийн клубыг ажиллуулаарай.

Жишээ

МХБ-ийн үйл ажиллагаанд хэрэгжүүлвэл зохих үр дүнтэй зарчмыг улс оронд авч үзсэн жишээ.

Сурагчдын сурлагын амжилт, хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлт нь хамтын үйл ажиллагааны цөм байна.
Хүүхдийн суралцахуйн болон бие хүний хөгжил төлөвшлийн ахиц өөрчлөлтөд судлагдахууны бүх багш үүрэг хариуцлагатай байна.
Мэргэжлийн болон заах арга зүй, сурган хүмүүжүүлэх харилцаа, хүүхдийн сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэг, чадвар, туршлагаа ямагт дээшлүүлэх хүсэл эрмэлзлэлтэй, байнга хөгжөөг байна.
МХБ нь хүүхдийн суралцахуйн амжилт болон тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэх, харилцан туршлага солилцоход тусгайлан цаг зарцуулдаг байна.
МХБ нь хамтдаа суралцагчдын сурах хэрэгцээ шаардлага, онцлог зэргийг оношлон түүнд үндэслэн авах хариу арга хэмжээг хамтдаа төлөвлөдөг байна.
МХБ-ийн үйл ажиллагаа нь тодорхой баримт нотолгоо бүхий үндэслэлд суурилсан байх нь үр дүнтэй.
МХБ нь бусад сургуулийн амжилт туршлагаас суралцдаг, түгээдэг байх хамтын хөгжлийн арга юм.
МХБ нь мэргэжлийн бусад байгууллага, хүмүүстэй хамтарч ажилладаг байх нь чухал юм. **(https://www.education.vic.gov.au/school/teachers/management/improvement/plc/)**

Зөвлөгөө:

- 5 дугаар ангийн багш, 6 дугаар ангид хичээл ордог багш нар хамтран МХБ-ийг үүсгэх боломжтой.
- МХБ-ийн гишүүдийн үйл ажиллагааны гол зорилго нь бага боловсролоос суурь боловсролын түвшинд шилжин суралцаж буй суралцагчдын суралцахуйн дасан зохицох процессыг дэмжихэд чиглэнэ.
- 6 дугаар ангид элсэн суралцаж байгаа хүүхдүүдийн суралцахуйд гарч байгаа бэрхшээлийг харилцан ярилцах, хүүхдүүдийг оношлох замаар илрүүлээрэй.
- Суралцахуйд гарч байгаа нийтлэг бэрхшээлийг даван туулахад багш нар харилцан мэдлэг, туршлагаа солилцох зөвлөлдөх уулзалтуудыг хийдэг байгаарай.
- МХБ-ийн уулзалт нь тодорхой асуудал бүхий жишээ тохиолдолд суурилсан бүтээлч шийдвэрийг эрэлхийлдэг байхад чиглээрэй.
- 6 дугаар ангид багш нар хамтын хичээлийг төлөвлөн зохион байгуулж үр дүнг хамтран хэлэлцдэг байгаарай.

Сургуулийн удирдлага багш нарын мэргэжлийн удирдлагад суралцагчийн дасан зохицолтыг тусгах боломжтой юу?

Багш нарын мэргэжлийн удирдлага гэдэг нь багшийн мэргэжлийн үйл ажиллагааг орчны зүгээс дэмжиж нөлөөлөх замаар хөгжүүлэх үйл явц бүхий тогтолцоо юм. Үүнд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг, удирдамж хамаарагдана.

Суурь боловсролын түвшинд хүүхдийн дасан зохицолтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөн туслах үйл ажиллагаа нь мэргэжлийн удирдлагын нэг чиглэл байж болох юм.

Удирдлагын дараах хэлбэр байж болно.

- Багш нарыг хөгжүүлэх албан ёсны хөтөлбөр боловсруулан суралцагчдын дасан зохицолтын талаарх мэдлэг, ур чадварыг олгох хөтөлбөр оруулж болох юм. Тухайн сургалтаар багш нар суралцагчийн сэтгэл зүйн онцлог, дасан зохицолтыг таних, сайжруулах практик арга зүйн талаар санаа бодлоо солилцож харилцан бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлж болно.
- Багш нарыг хөгжүүлэх албан ёсны бус хэлбэрийг ашиглах нь ур дүнтэй. Энд багш нар суралцагчийн дасан зохицолттой холбоотой асуудлаар албан бус уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж болно.



ЗӨВЛӨМЖ

- Бага ангийн 5 дугаар ангиас эхлэн 7 дугаар анги хүртэлх хугацаанд хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн дасан зохицолтыг дэмжих тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлээрэй.
- Багш нарыг хөгжүүлэх албан ёсны хөтөлбөрт дунд ангийн суралцагчдын дасан зохицох чадварыг дэмжих, удирдах талаар тусгах, жишээлбэл, багшийн мэргэжил дээшлүүлэх албан ёсны хөтөлбөрт тусгаж ур дүнг нь туршиж үзээрэй.
- Сургалтад хамрагдаж буй багш нарын сэтгэл зүйн бэлэн байдлыг бий болгоход анхаарч ажиллаарай.
- Дунд ангид орсноор суралцагчийн сурах орчин, өөртөө хандах, үе тэнгийнхэн болон эцэг эхчүүдтэй харилцах харьцаа хандлага хэрхэн өөрчлөгддөг, энэ нь сурч хөгжихөд бэрхшээл үүсгэх эсэх, түүнээс урьдчилан сэргийлэх, даван туулах талаар тогтмол мэдээлэл, мэдлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг байгаарай.
- Багш нар хоорондоо 5-6 дугаар ангийн суралцагчдын онцлогийн талаар бодит мэдээлэл, туршлагаа солилцож, асуудлыг шийдэх арга замын тухай санаа бодлоо солилцохыг байгууллагын соёл болгон төлөвшүүлээрэй.
- Бага ангийн 5 ба дунд ангийн 6 дугаар ангийн суралцагчдын танин мэдэхүй, мэдлэг, чадвар, туршлага, зан төлөв, харьцаа хандлага сонирхлыг сургуулийн сэтгэл зүйчтэй хамтран хичээлийн жилийн эхэн, дунд, төгсгөлд нь судлан тодорхойлж,мэдээллийн цахим бааз бүрдүүлж, ур дүнд тулгуурласан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг байгаарай.

- Анги бүлэг доторх асуудлыг хичээл ордог багш нар хоорондоо илэн далангүй ярилцдаг сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлээрэй.
- Багш нарын бие хүний сэтгэл зүйн төлөвшил, харилцаа хандлага дахь ёс зүйн шаардлагыг тодорхой болгож, бодит хэрэгжилтэд анхаарч ажиллаарай.
- Сургалтын үйл явц нь суралцагчдад сөрөг нөлөө үзүүлэхүйц дарамт шахалтгүй талаас нь багшид зөвлөн тусалдаг тогтолцоог бүрдүүлээрэй.

Жишээ 1.

7-р ангийн сурагчийн ярианаас

Биднийг 5 дугаар ангид байхад багш маань та нар одоо бие дааж сурахад хичээгээрэй. 6 дугаар ангид ороход чинь бага ангийн багш шиг та нартай нэг бүрчлэн багш нар “зууралдахгүй” шүү. Сураагүй нь хоцрогдоно гэж хэд хэдэн удаа хэлж байсан.
Дунд ангид ороход олон багш нар хичээл заахад ойлгомжгүй зүйл надад их гарч байсан. Сургуулиас хүүхдүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авдаг.
Манай математикийн багш “хичээлдээ сайн” 2 охин, 4 хөвгүүнтэй л сайн харилцана. Бусдыг нь тоохгүй.Бодлогоо бодоод үзүүлэхэд дандаа хэнээс хуулсан бэ гэж асуудаг. Нэг удаа сургуулиас санал асуулга авсны дараа та нар намайг муу дүгнэсэн байсан гээд их муухайгаар биднийг хэлсэн. Гэтэл нээлттэй хичээл дээр биднийг “миний хүүхдүүд” гэж харилцдаг.
Муухай үгээр биднийг хэлснийг нь сэтгэл зүйчид хэлсэн чинь дараа нь биднийг та нар үг дааж сурахгүй яагаад хов зөөгөөд байгаа юм бэ, ийм байвал ахлах ангидаа ороод бүр юу ч сурахгүй шүү гэж хэлсэн.
Бид сэтгэл зүйчдээ итгэдэггүй, хандах ч дургүй, учир нь нууц хадгалдаггүй, ууртай. Хичээл орж байхдаа багш нар ус аваад ир, тэр багшаас тийм юм аваад ир гэдэг, бид гарахаар коридорт сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс явуулдаггүй, хичээлдээ ор гээд загнадаг, багш нар үүнийг ойлгохгүй дахиад л багш авч ир гэсэн гээд хэлээд яв гээд уурладаг, энэ нь бидэнд маш хэцүү байдаг талаар бид хоорондоо ярьдаг. Том ангийнханд бүр л хэцүү байдаг байх.
Үүнээс болоод миний 2 найз хувийн сургуульд шилжин суралцсан.
Ер нь бага ангид байхад л гоё байсан байна. Дунд ангид орсон чинь багш нар нь их ууртай. Ялангуяа манай сургуулийн математик, биеийн тамирын багш нар байнга хүүхэд загнадаг.

Зөвлөгөө:

- Суралцагчдаас санал асуулга авахдаа нууцлалыг чандлан хадгалах
- Багш, суралцагч бүр сургуулийн дүрмийг нарийн мэддэг байх, үүнийг харагдахуйц газар байрлуулах
- Дүрмийг сахин биелүүлэх талаар багш суралцагчдад адил шаардлага тавьдаг байх
- Дээрх тохиолдолд хичээлийн үед сургууль дотор хүүхэд явж байвал багшид нь биечлэн шаардлага тавьдаг байх
- Хүүхдүүдтэй удирдлагын зүгээс нээлттэй ярилцлага хийж, нөхцөл байдлыг тодруулах, нууцлалыг хадгалах тал дээр анхаарч ажиллах нь үр дүнтэй юм.

Жишээ 2.

Багшийн мэргэжлийн удирдлагыг бий болгоход анхаарах зүйл

- ✓ Багшид зөвлөн туслах дэмжихэд чиглэсэн удирдлага нь багшийг сэтгэл санааны дарамт зовнилд оруулахаас зайсхийх нь чухал

- ✓ Хувь хүний эерэг чанарыг тодруулж, өөрийн үнэлэмжид нь сөрөг ул мөр үлдээхээс бүрэн татгалзах, үүнийг тооцож үздэг байх
- ✓ Хамт олны дунд багшийн нэр хүндийг эрхэмлэх, ялангуяа багш нар олон хүний дотор сэтгэл гонсойсон харагдах дургүй байдгийг ямагт санах
- ✓ Багш бүр сургалт хөгжлийн олон төрлийн үйл ажиллагаанд санаа бодлоо, туршлагаа чөлөөтэй илэрхийлэх боломж бололцоог бий болгох
- ✓ Сургалт хөгжлийн үйл ажиллагаанд илэрхий жишээ, тохиолдолд задлан шинжлэх, дүгнэх, шийдэх гэх мэт бүтээлч арга хэлбэрийг бий болгох
- ✓ Багш нар сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй хамрагдах нь өдөр тутмын мэргэжлийн үйл ажиллагаа, зан төлөвийн хэв маягийг нь өөрчилдөг хэмээн боловсролын удирдахуйн ухаанд үздэг ажээ.

Зөвлөгөө

- Удирдах шатны ажилтнууд багштай харилцахдаа ямагт ёс зүйн хэм хэмжээг баримтлаарай.
- Багш бүр хүүхдийг хүндэтгэн харилцах мэдрэмж, ур чадвартай байх талаар байнга зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлээрэй.
- Багш болон мэргэжлийн бүлгийн хөгжлийн ажлын үр дүнгийн үнэлгээнд хүүхэдтэй харилцах ёс зүйн шалгуурыг тодорхойлж, мэдлэг мэдээлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулаарай.
- Сургалт хөгжлийн үйл ажиллагаа нь тодорхой асуултад хариулт өгөхөд чиглэсэн бүтээлч шинжтэй байх нь үр дүнгээ өгдгийг санаарай.
- Багш нар хоорондоо мэдлэг, туршлагаа хуваалцах мэргэжлийн бүлэг дотроо асуудлаа дэвшүүлэн тавьж шийдвэрлэх багийн ажлыг дэмжээрэй.

Ашигласан материал

1. Barbara Bruns, Deon Filmer, Harry Anthony Patrinos. (2011). *Making Schools Work: New evidence on Accountability reforms.*
2. https://www.education.vic.gov.au/school/teachers/management/improvement/plc/. (огноо байхгүй).
3. Боловсролын хүрээлэн . (2018). *"Монголын хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур үзүүлэлтийг сургалтын практикт нэвтрүүлэх нь" .* Улаанбаатар .
4. БСҮХ. (2023). *Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог.* УБ,: Соёмбо Принтинг.
5. БҮТ. (2015, 2018). *Боловсролын чанарын үнэлгээний судалгаа: эцэг эхийн асуулга .*
6. Н. Бэгз, С.Санжаабадам нар . (2021). *Нэр томьёоны тайлбар толь - Хүний хөгжил .* Улаанбаатар хот .
7. Н.И.Шевандрин. (1995). *Социальная психология в образований .* Москва: Владос .
8. Хүүхдийг ивээх сан . (2018). *Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ .* Улаанбаатар .